



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 он 12 сарын 15 өдөр

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Зорилго: Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжиж, эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2025.12.15.

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1.НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:							
Зорилт 1.1 Удирдлага зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн зохион байгуулах							
1.1.1	Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа • “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” • “Эрүүл шүд” • “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” • “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллана.	500.0	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Хэрэгжилт 91.3%	92%	1. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЭМС-дын 2022.10.31-ний өдрийн А/780 дугаар тушаал) ний хэрэгжилт 97.3% 2. Цартахлын дараах эрүүл мэндийн салбарын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЭМС-дын 2024.04.18-ний өдрийн А/180 дугаар тушаал)-ний хэрэгжилт 96.4% 3. Элэг бүтэн Монгол арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЭМС-дын 2022.12.05-ний өдрийн А/577 дугаар тушаал)-ний хэрэгжилт 91% 4. Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын 2024-2026 оны арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЭМС-дын 2024.03.29-ний өдрийн А/137 дугаар тушаал)-ний хэрэгжилт 94%	100%

						5. Эрүүл шүд арга хэмжээ төлөвлөгөө (МУ-ын Эрүүл мэнд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024.01.19-ний өдрийн А/27, А/25 дугаар тушаал)-ний хэрэгжилт 91% 6. Сэтгэцийн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЭМС-дын 2024.03.29-ний өдрийн А/148 дугаар тушаал)-ний хэрэгжилт 90% 7. Иргэний эрүүл мэндийн боловсролын дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын Эрүүл мэнд, Боловсрол шинжлэх ухаан, Биеийн тамир спорт, Хөдөлмөр нийгмийн хамгаалал сайдын 2024.02.20-ний өдрийн А/75, А/09, А/73, А/34 дугаар тушаал)-ний хэрэгжилт 90% 8. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын Ерөнхий сайдын 2024.05.14-ний өдрийн 71 дугаар захирамж)-ний хэрэгжилт 99.2% 9. Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын Эрүүл мэнд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2025.02.06-ний өдрийн А/53, А/37 дугаар тушаал)-ний хэрэгжилт 90% 10. Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2025.05.30-ний өдрийн А/219 дугаар тушаал)-ний хэрэгжилт 87.4% 11. Хорт хавдраас сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр (МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2025.06.12-ний өдрийн А/241 дугаар тушаал)-ний хэрэгжилт 88.3% 10 арга хэмжээний төлөвлөгөө, 1 үндэсний хөтөлбөр хэрэгжилтийн дундаж 93 %-тай байна.	
--	--	--	--	--	--	--	--

1.1.2	Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах олон нийт удирдсан хяналтын тогтолцоог бий болгох төслийн хүрээнд эрүүл мэндийн зөвлөл байгуулан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллана	1,000. 0	Төлөвлөгөөний хэрэгжилт	-	Төлөвлөгөөний хэрэгжилт 88%	Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд ОНУХТ-ны салбар зөвлөлийг 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан АЗД-аар баталгаажуулсан. ОНУХТ-ын Салбар зөвлөлийн дүрмийг 6 чиглэлээр 69 заалтаар боловсруулан батлуулсан. Салбар зөвлөлийн төлөвлөгөөг боловсруулан НБХ-ийн даргаар батлуулан ажиллаж байгаа бөгөөд сар бүрийн сүүлийн 7 хоногийн 3 дахь өдөр салбар зөвлөл хуралдан тухайн сарын ажлыг дүгнэх, дараагийн сард хийх ажлыг төлөвлөн нийт 8 удаа хуралдсан. Салбар зөвлөлөөс хэрэгжүүлсэн үйл ажиллагаа: ➤ Орон нутгийн анхан шатны шийдвэр гаргагч сум багийн засаг дарга, ААНБ-ын 40 удирдах ажилтанд ОНУХТ талаар танилцуулга мэдээлэл өгч, санал солилцох уулзалт ➤ Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрөөр ЕБ-ын 1-р сургуулийн ахлах бүлгийн сурагчдын дунд Эссэ бичлэгийн уралдаан, Дархан-Өргөө Уул уурхайн коллежийн салбар сургуулиудын хооронд Дэвжээ тэмцээн ➤ СЭМТ, ӨЭМТ, баг, эмийн сангууд болон аж ахуй нэгж нийт 140 байгууллагад сүрьеэгийн зурагт хуудас, боршур байршуулсан. ➤ Сүрьеэтэй өвчтнүүдтэй ялгаварлан гадуурхалт, сэтгэл зүйн байдал, эмчилгээний талаар ярилцлага уулзалт хийж зөвлөгөө мэдээлэл өгсөн. ➤ ОНУХ-ын судалгаа хийж дүгнэлтийг танилцуулсан. ➤ Дархан дахь салбар зөвлөлийн гишүүдэд дата мэдээлэл цуглуулах, харилцаа хандлагын талаар сургалт хийсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 82.6%	93.8%
-------	--	-------------	-------------------------	---	-----------------------------	--	-------

1.1.3	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын хамтын ажиллагаа хариу арга хэмжээний чадвахийг сайжруулна	500.0	- Эрсдэлийн үнэлгээ хийх. -Дадлага сургалтад хамрагдсан ЭМА	Хээрийн эмнэлэг дэлгэх дадлага сургалтад 50 ЭМА оролцсон.	Салбар хоорондын хамтарсан дадлага, сургуулилт хийсэн байна.	Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан ШС-24/007 дугаартай хамтран ажиллах гэрээний 3.6 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны 01-А/125 тоот захирамжийн дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулагдсан. Үзлэгт аймгийн Эрүүл мэндийн албаны эмч, мэргэжилтнүүд гамшгийн үед хэрэглэгдэх эрүүл мэндийн хүний нөөц, мэргэжлийн ангийн төлөвлөгөөний хэрэгжилт, техник, хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг ханган ажилласан. Эрүүл мэндийн албаны 110 албан хаагч, 5 техник хэрэгслийн бэлэн байдал хангаж 84.4% үнэлэгдсэн байна. Эрүүл мэндийн албаны бэлтгэл бэлэн байдлыг хангах хүрээнд гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 2 удаа тодотгол хийж, сургалтыг салбарын хүрээнд 4 удаа 450 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. Хээрийн эмнэлэг дэлгэх дадлага сургуулийг 2 удаа зохион байгуулсан. 2025 оны 05 сарын 15-ны өдрөөс Дархан-Уул аймагт Улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдож бүртгэгдэж эхэлсэн. 2025.05.17-ны өдрөөс сэжигтэй тохиолдлууд нь лабораториор батлагдсан тул ЭМГ-ын ТУТ-ны баг эрсдэлийн үнэлгээ хийж ажилласан. Эрсдэлийн үнэлгээний дүн: Магадлалын түвшин тогтоох оноо 3.0, Үр дагаварыг түвшин тогтоох оноо 2.4 буюу Аймгийн хэмжээнд улаанбурхан өвчний эпидемийн цар хүрээ нэмэгдэх эрсдэл ӨНДӨР гарсан тул идэвхжлийн II зэрэгт шилжиж Тохиолдлын удирдлагын зарчмаар ажилласан. Монгол улсын Шадар сайдын 2023 оны 4-р сарын 24-ний өдрийн 28 дугаар тушаалын 2-р хавсралтад заасан “Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний алгоритм”-ыг ашиглан хийсэн Түргэвчилсэн үнэлгээгээр Дархан-Уул аймгийн ТТӨ-ий эрсдэл ДУНД ЭРСДЭЛТЭЙ үнэлэгдсэн. Монгол улсын Шадар сайдын 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн баталсан “Гамшгийн эрсдэлийн	100%
-------	---	-------	---	---	--	---	------

						ерөнхий үнэлгээ хийх удирдамж"-ийн дагуу ТТӨ-ий түргэвчилсэн үнэлгээ хийсэн. 2025 оны 48-р долоо хоногийн томуугийн матриц үнэлгээгээр ТТӨ 158.3, АЗЦХХ 8.8 промилл буюу "АЛАГ ЦООГ ДЭГДЭЛТИЙН ҮЕ" дээр байна. Өнгөрсөн 47-р долоо хоногтой харьцуулахад амбулаторийн өвчлөл 107.6 промиллоор, эмнэлэгт хэвтэлт 4.0 промилоор тус тус өссөн байна.	
1.1.4	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна	200.0	-Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан хүн	1000	2000	"Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлье" сэдвээр ажлын байран дээр сургалтыг 8 байгууллагуудын 560 эрэгтэй албан хаагчдад зохион байгуулсан. Дархан сумын 13-р баг, Бүх нийт-Боловсролын төлөө Дархан салбар, Дархан Политехникийн коллеж, Цагдаагийн газар, өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран Үе тэнгийн дээрэлхлэлт, Цахим донтолт, Өсвөр үеийн сэтгэлзүй, электрон тамхины хор уршиг сэдвүүдээр ЕБС-ын 6-11 ангийн 921 сурагч, 260 оюутан залуусыг хамруулан 6 удаа сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. - Аймгийн ИТХ-ын санаачлагаар "Эх оронч Дарханчууд" 1 сарын аяны хүрээнд Эрүүл мэндийн газар, Боловсролын газар хамтран ЕБС-ын сургууль, Коллежийн 17, 18 настай эрэгтэй сурагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж 1154 эрэгтэй сурагчид хамрагдахаас 936 сурагчид хамрагдаж хамрагалт 81.1%-тай. Үзлэгт хамрагдсан 936 суралцагчдаас хэвийн жинтэй 696 (87.1%), илүүдэл жинтэй 84 (9%), 1-р зэргийн таргалалт 26 (2.8%), 2-р зэргийн таргалалт 7(0.8%), 3-р зэргийн таргалалт 2(0.2%) хувь байна. Зан төрхийн хөгжлийн үнэлгээгээр хэвийн 602 (64.3%), сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтөд өртөж буй хүүхдийн тоо 334 (36%) байна.	100%

						Мэс заслын эмчийн үзлэгт хуйхнагийн венийн бүдүүрэл, Тээрхийн арьс хэт их, фимоз ба парафимозтой холбоотой өвчлөл бүртгэгдэж байна. Арьс харшлийн эмчийн үзлэгт арьсны эмгэгтэй 57 (6%) байна. Өсвөр насны сурагчдын дундах амны хөндийн өвчлөлд шүдний цоорол давамгайлж байна. Мөн 22.6 %-д холын хараа муутай гарсан байна.	
Зорилт 1.2. Нийгмийн эрүүл мэндийн тандалт, судалгаа хийж, үр дүнг шийдвэр гаргагч нар болон олон нийтэд мэдээллээр хангаж ажиллах							
1.2.1	Томуугийн харуулдан тандалтын тогтвортой байдлыг хангаж, үйл ажиллагааг бэхжүүлэх, эргэн мэдээллээр хангаж ажиллана.	-	Томуугийн тандалт эргэн мэдээллийн тоо	52 долоо хоногийн эргэн мэдээлэл	52 долоо хоногийн эргэн мэдээлэл	2025 оны 48-р долоо хоногийн томуугийн матриц үнэлгээгээр ТТӨ 158.3 АЗЦХХ-8.8 промилл буюу АЛАГ ЦООГ ДЭГДЭЛТИЙН ҮЕ дээр байна. Өнгөрсөн 47-р долоо хоногтой харьцуулахад амбулаторийн өвчлөл 107.6 промиллоор, эмнэлэгт хэвтэлт 4.0 промиллоор тус тус өссөн байна.	100
1.2.2	Халдварт бус өвчлөлийн эрсдэлт хүчин зүйл, эрүүл мэндийн мэдлэг хандлага, дадал үнэлэх суурь судалгаа хийнэ	200.0	Судалгааны тайлан	-	Судалгаа хийж үр дүнг ЭМГ-ын зөвлөлд танилцуулсан байна.	- Халдварт бус өвчлөлийн эрсдэлт хүчин зүйл, эрүүл мэндийн мэдлэг, хандлага, дадлын суурь судалгааны асуумжийг боловсруулж, цахим судалгаанд 331 хүн хамруулсан. Судалгаанд 81.6% нь эмэгтэйчүүд эзэлж байна. Оролцогчдын 77.9% нь зохистой хооллолтын зөвлөмжийн талаар мэдэхгүй, өглөөний цайгаа тогтмол хэрэглэдэггүй (58.9%). Өдөрт 30 мин дээш дасгал хөдөлгөөн хийдэг нь ердөө 23%. 62.2% нь стрессд өртдөг бөгөөд 52.5% нь стрессээ ямар нэг байдлаар тайлдаг байна. Архи тогтмол хэрэглэдэг нь 9.4%, тамхи татдаг нь 11.2%, өдөрт 4 цагаас дээш дэлгэцийн хэрэглээтэй 52% байна. Эрт илрүүлэгт хамрагдсан нь 21.1%. Усыг буцалгаж хэрэглэдэг 75.5%, шүүлтүүр хэрэглэдэг 39%. Агаарын бохирдлоос хамгаалах арга хэмжээ авдаггүй нь 34.7%.тай байна. 2026 онд ХБӨ мэдлэг хандлагын	70%

						судалгаанд хүн амын хамралтыг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
1.2.3	Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, өвчлөлд судалгаа хийж үр дүнг тооцож ажиллана.	-	Судалгааны тайлан	1	Судалгаа хийж үр дүнг ЭМГ-ын зөвлөлд танилцуулсан байна.	Эрэгтэйчүүдийн өвчлөлийн статистик үзүүлэлтэд хагас жилийн байдлаар судалгаа хийхэд: Эрэгтэйчүүдийн дундаж наслалт улсын хэмжээнд 67.92 байгаа бол Дархан-Уул аймагт 64.23 буюу улсын дундаас 3.69 насаар бага байна. Эрэгтэй эмэгтэй хүйсийн насны зөрүүулсад 9.2 бол манайд 10.2 насны зөрүүтэй байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан иргэдийн 40.3% нь эрэгтэйчүүд байна. Эрэгтэйчүүдэд зонхилон тохиолдож байгаа тэргүүлэх өвчлөлд: Амьсгалын тогтолцооны өвчин 36,1%, хоол шингээх эрхтний өвчин 15,3%, Арьс халимны өвчин 7,9%, нүд ба түүний дайврын өвчин 1,8%, цусны эргэлтийн эмгэг 6,8%, осол гэмтлийн өвчин 5% тус тус бүртгэгдсэн байна. Эрэгтэйчүүдийн нас баралт өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2.16 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн эрэгтэйчүүдийн нас баралтын тэргүүлэх өвчлөлийг авч үзвэл Цусны эргэлтийн тогтолцоо 35.55%, Хавдарын нас баралт 35.65%, Осол гэмтэлийн нас баралт 13.17%, Амьсгалын тогтолцооны өвчний нас баралт 5.42%, Хоол шингээх эрхтний өвчин 4.65% эзэлж байна. Нас баралтын тэргүүлэх шалтгаан болох хавдрын өвчний нас баралт, осол гэмтлийн нас баралт ихэнх хувийг эзлэж байна. Үүнтэй холбогдуулан Нэгдсэн эмнэлгийн амбулаторит Эрэгтэйчүүдийн /Андрологийн/ кабинет нээж оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлдэг болсон.	100%

1.2.4	ХДХВ, тэмбүүгийн тандалтыг зохион байгуулж, тархалтын судалгаа хийж үр дүнг тооцож ажиллана.	200.0	Судалгааны тайлан	1	Судалгаа хийж үр дүнг ЭМГ-ын зөвлөлд танилцуулсан байна.	Глобаль сангийн дэмжлэгтэй Эрүүл мэндийн яам, ХӨСҮТ, АШУҮИС-ын судлаач эмч нарын баг аймгийн НЭ, НЭМТ, Хонгор сумын ЭМТ, Госхот өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 24 эмч, эмнэлгийн ажилчдаас судалгаа авсан. Глобаль сан ДЭМБ, ЭМЯ, ХӨСҮТ, “Залуус эрүүл мэнд” ТТБ-тай хамтран ЭБЭ-ийн бүртгэл судалгааг орон нутгийн хэмжээнд гаргасан. /Нууцлалын кодтой/ 3 жил тутам хийгдэх ЭБЭ судалгаа хийгдэж эхэлсэн бөгөөд одоогоор судалгаааны явц 12%-тай явагдаж байна.	70%
1.2.5	Өсвөр насны охидын жирэмслэлтийн судалгаа хийж үр дүнг тооцож ажиллана.	-	Судалгааны тайлан	-	Судалгаа хийж үр дүнг ЭМГ-ын зөвлөлд танилцуулсан байна.	ЭМЯ, ЭХЭМҮТ, НҮБ-н Хүн амын сантай хамтран Монгол Улсын хэмжээнд “Өсвөр үеийн жирэмслэлтийн өнөөгийн байдал, нөлөөлөх зарим хүчин зүйлс” сэдэвт судалгааны ажлыг 2025.11.01-с эхлүүлж улсын хэмжээнд нэгдсэн байдлаар үр дүнг тооцож ажиллах чиглэл ирүүлсэн. ЭМГ-ын ЭТҮХ-ийн даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй багаар 12 сард Өсвөр насны охидын жирэмслэлт, төрөлтийн байдлыг судлах нь судалгааны ажлыг сүүлийн 5-н жилийн дата баазыг үүсгэх, тохиолдолд суурилсан судалгааны ажлыг хийсэн. Судалгаанд 2020-2024 оны хооронд 15-19 насны охидын 388 төрөлт бүртгэгдсэн. Үр хөндөлт 10 тохиолдол буюу 2.5%, зулбалт 4 тохиолдол буюу 1% бүртгэгдсэн, 40 (32%) тохиолдолд Төрөх хүчний хямралтай, Кесаров хагалгаа 31 (7.9%)-аар төрсөн байна.	100%
1.2.6	Сүрьеэгийн тархалтын чиглэлээр ОНУХ судалгаа хийж үр дүнг тооцож ажиллана.	200.0	Судалгааны тайлан	-	Судалгаа хийж үр дүнг ЭМГ-ын зөвлөлд танилцуу	614 хүнээс судалгаа авсан байна. Судалгааны оролцогчдын хувьд 313 буюу 50.9% эрэгтэй, 48.1% эмэгтэй, 18-аас дээш насны иргэд хамрагдсанаас 26-55 насны иргэд 66.3%-ийг эзэлж байна. Судалгаанд хамрагсдын 23.1% нь аймгийн нэгдсэн эмнэлгээс, Сүрьеэгийн диспансераас 16.8%, СЭМТ ӨЭМТ-	100%

					лсан байна.	с14.8% нь, бусад чиглэлээр 43.3% нь тусламж үйлчилгээ авсан. Судалгааны үр дүнг 5 онооны үнэлгээний системээр дүгнэсэн. Тусламж үйлчилгээний үр дүн: Боломжит байдлын дундаж үзүүлэлт 4.2 Хүртээмжтэй байдлын дундаж үзүүлэлт 4.4, Зөвшөөрөгдөх байдлын дундаж үзүүлэлт 3.90, Чанарын дундаж үзүүлэлт 3.56-аар үнэлэгдсэн. Ялгаварлан гадуурхалт болон ноцтой үйлдэл, мэдээллийн асуумжийн үр дүн: Ялгаварлан гадуурхалтад өртсөн эсэх асуумжид 577 буюу 93,9.% нь үгүй, 6,1 % нь тодорхой хэмжээнд өртсөн. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд эмзэглэж тавгүйтэж байсан эсэх асуумжид 94% нь үгүй, 6% нь тийм гэж хариулсан. Судалгааны ажилд суурилан нэгдсэн эмнэлгийн Амбулатори 2 тасгийн Сүрьеэгийн кабинетын агааржуулалтын системийг бүрэн шинэчилсэн. Орчин нөхцөлийг сайжруулан 4 өрөөнд засвар хийсэн. Үйлчлүүлэгчийн урсгалыг зөв болгосон.	
Зорилт 1.3. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдлэг хандлагыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах							
1.3.1	Засгийн газрын 224 дүгээр тогтоол “Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр”-ын хэрэгжилтийг ханган үйл ажиллагаа зохион байгуулна.	500.0	Зохион байгуулсан тэмдэглэлт өдрийн тоо	38	38	Монгол улсын Засгийн газрын 2001 оны тогтоолын дагуу “Нийгмийн эрүүл мэндийн нэрэмжит өдөр”-өөр өдөрлөг 29, аян 14, дэлхийн өдөр 19 удаа тус тус зохион байгуулж, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд 48319 хүнийг хамруулсан байна. Мөн орон нутгийн хэвлэл мэдээллийн DBS, RGB телевизүүд, Цэц.мн сайттай FM104.5 хамтран 68 мэдээ, тодруулга ярилцлага 7, мэргэжлийн эмчийн зөвлөгөө 12, реел 18 удаа, эрүүл мэндийн 6 контент бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн байна.	100%

						Аймгийн ИТХТ-ийн 2013 оны 15 дугаар тогтоолын дагуу “Эрүүл мэндийн өдөр” дэвтэр, туг аялуулах хуваарийн дагуу 18 байгууллагын 549 албан хаагчдад эрүүл мэндийн сургалт дэмжих арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.	
1.3.2	Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчний талаар эрүүл мэндийн боловсрол олгох , эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулна.	500.0	Хамрагдсан хүн ам	19724	20.000	Монгол улсын Засгийн газрын 2023.08.30-ны өдрийн “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай” 321 дугаар тогтоолын дагуу 2025 онд 5 зорилт бүхий 27 чиглэлийн арга хэмжээний төлөвлөн Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээнд 36127 хүн хамрагдсан. “Халдварт өвчний зөвлөгөөн”-ийг Халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээрийг бууруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх тандалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилготой зохион байгуулж Эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтан, эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, Орхон, Хонгор, Шарын гол сумын ЗДТГ-ын харьяа холбогдох удирдах ажилтан 108 хүн хамрагдсан. - Халдварт бус өвчнөөс сэргийлэх зөвлөгөөнд Эрүүл мэндийн байгууллагуудын 33 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж Халдварт бус өвчний өнөөгийн байдал, цаашид хамтран ажиллах талаар санал хэлэлцүүлсэн. -Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулья зөвөлгөөнийг эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтан, сүрьеэгийн чиглэлээр ажиллаж байгаа эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг 25 хүн оролцуулан зохион байгуулсан.	100%

						- Дархан сумын Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар, Боловсролын газар, Залуучууд театр хамтран “Бидний нандин нас” дэвжээ тэмцээн зохион байгуулж 9 сургуулийн 900 гаруй хүүхэд хамрагдсан. - Дэлхийн Тамхигүй өдрийг тохиолдуулан Ирээдүйг сорсон хор уриан дор 10 хоногийн аян зохион байгуулж “Тамхины хор хөнөөл, Дам тамхидалт, Электрон тамхи” сэдвүүдээр сургалт нөлөөллийн үйл ажиллагааг сургалтад 47 байгууллагын 150 албан хаагчдыг хамрагдсан.	
1.3.3	Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.	100.0	Хамрагдсан иргэд	2000	2500	Хүүхэд өсвөр үеийнхэнд чиглэсэн “Сэтгэцийн эрүүл мэнд”-ийг дэмжих, “Архи, Утаат болон Электрон тамхи”-ний хор нөлөө, “Сэтгэц нөлөөт мансууруулах бодис”-ийн хор уршиг, урьдчилан сэргийлэх арга замын талаар хийсэн урьдчилан сэргийлэх, мэдлэг ойлголтыг төлөвшүүлэх сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж 2664 өсвөр насны хүүхдүүд хамрагдсан байна.	100%
1.3.4	Осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, авто тээврийн гэх мэт) үйл ажиллагаа зохион байгуулж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулна.	100.0	Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан иргэд	1100	1500	- “Агшин бүрт анхаарал сэрэмжийг нэмж эрсдлийг бууруулъя” аянг зохион байгуулж, Дархан политехник коллеж, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн оюутан залууст “Осол гэмтлээс хэрхэн урьдчилан сэргийлье” сэдвээр сургалт зохион байгуулж нийт 250 оюутан хамрагдсан. - “Ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлье” сэдвийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн нийт 830 өсвөр үеийн сурагчдад, СӨББ-н нийт	100

						553 хүүхэд, 50 багш, 241 ахмад настанг тус тус хамруулсан. Болзошгүй осол гэмтлээс сэргийлье цахим эмчийн зөвлөгөө 5 төрлөөр бэлтгэн хүн амд эрүүл мэндийн байгууллагууд, орон нутгийн цахим 17 сайтаар дамжуулан хүргэсэн.	
Зорилт 1.4. Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах, илэрсэн өвчлөлийг хянах, эрт илрүүлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх							
1.4.1	Эрүүл уушги уриан дор Хаалганаас хаалганд сүрьеэгийн зорилтот бүлгийн иргэдэд урьдчилан сэргийлэх илрүүлэг үзлэг зохион байгуулж илэрсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүнэ.	300.0	Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо, илэрсэн өвчлөл, эрүүлжилт	2700	3600	Эрүүл уушги, Хаалганаас хаалганд сүрьеэгийн зорилтот бүлгийн иргэдэд урьдчилан сэргийлэх илрүүлэг үзлэгийг Шар зам хоршоо, Орон гэргүй иргэдийн түр байршуулах байр, Хог тээвэрлэлт, Хот тохижилт, хаалттай 435-р хорих анги, 18-р баг болон 3 сум, 5 ӨЭМТ эрсдэлт бүлгийн иргэд, Жаргалтай амьдрал төвийн үйлчлүүлэгч 3607 хүн хамрагдсанаас 10 сүрьеэг илрүүлэн 100% хяналтанд авсан.	100%
1.4.2	Сүрьеэгийн далд халдвартай тохиолдлын эмчилгээнд хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ	-	Хамрагдалтын хувь	50	70	Сүрьеэгийн уушгины халдвартай хэлбэр болон ОЭДС-тэй 52 өвчтний 122 хавьтлаас 70 хавьтал буюу 57.3%-ийг урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулсан.	81.8%
1.4.3	ХДХВ, тэмбүүгийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах, халдвартай бүртгэгдсэн иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулах, эмчилгээний үр дүнг тооцож ажиллана.	-	Үзлэгт хамрагдсан зорилтот бүлгийн иргэдийн хувь	90	100	БЗДХ-ын урьдчилан сэргийлэх үзлэгт 10493 хүн хамрагдснаас 158 тохиолдол илэрсэнг хавьтлын хамт 100% эмчлэн эрүүлжүүлсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Тэмбүү-14 тохиолдолоор бага 15%-иар буурсан, трихоманиаз-3 тохиолдолоор бага 14%-иар буурсан, заг хүйтэн-11 тохиолдлоор их 14%-иар нэмэгдсэн байна.	100%

Зорилт 1.5. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, олон нийтийн оролцоог хангах

1.5.1	Тархвар судлалын заалт болон сайн дурын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэн, дархлаажуулалтын тасралтгүй байдлыг хангаж ажиллана.	-	Дархлаажуулалтын хамраглалтын хувь	94	97	- Товлолын дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралт 99.2%-тай байна. - ХГВ-ийн дархлаажуулалт 55.6% байна. Сайн дурын дархлаажуулалтад: В вируст гепатитын эсрэг вакцинд 15-59 насны 696 хүн, хүний папиллома вирусийн эсрэг вакцинд 17-20 насны 12 хүн хамрагдсан. Хачигт энцефалитийн эсрэг вакцинд 215 хүнийг, Галзуугийн эсрэг вакцинд 255 хүн хамрагдсан байна. Томуугийн вакцинд 8860 хүн хамрагдсан байна.	90%
1.5.2	Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулна.	300.0	Олон нийтийн арга хэмжээнд оролцсон иргэний тоо	1000	2500	ХГБХХГ, ЭМГ, Боловсролын газар хамтран Ерөнхий боловсролын 26 сургуулийн 7-11 дүгээр ангийн 280 сурагчдыг тусгай хөтөлбөрөөр Үе тэнгийн -Эерэг нөлөөлөгч сургагч багшаар бэлтгэн "Өсвөрийн эмч" клуб байгуулан ажиллаж байна. Амны хөндийн эрүүл мэнд сургалтыг 642 сурагчид, 2 цэцэрлэгийн 77 хүүхдүүд, ААНБ-ын 151 ажилтанд, зохион байгуулсан. "Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис, Донтолт, Утаат болон Электрон тамхины хэрэглээ, хор нөлөө, Сэтгэцийн эрүүл мэнд"-ийн талаар эрүүл мэндийн боловсрол олгох, мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх сургалтад ЕБС-иудын ахлах ангиудын сурагчид, Албан байгууллагуудын албан хаагчид, 1400 хүн хамрагдсан байна.	100%
1.5.3	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, ажлын байр хөдөлгөөн өрнүүлж, аж ахуй	1,500.0	Эрүүл мэндийг дэмжигч	-	1-2 ЭМД байгуулл	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвөөс Халдварт болон халдварт бус сэдвээр 37 албан байгууллагын ажлын байрны сургалтыг зохион байгуулж, Эрүүл мэндийг дэмжигч ажлын байр,	100%

	нэгж байгууллагыг идэвхижүүлж ажиллана.		байгууллагын тоо		ага болгох	байгууллага болох шалгуур үзүүлэлтийг танилцуулан 854 албан хаагч хамрагдсан. Эрүүл мэндийг дэмжигч байгууллагаар Аминхолбоо ӨЭМТ шалгарсан байна.	
1.5.4	Эх, хүүхдэд ээлтэй Эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж шалгаруулахад дэмжлэг үзүүлж, иргэний нийгэм, олон нийт, хувийн хэвшлийг татан оролцуулахад чиглэсэн ухуулга нөлөөлөл, сурталчилгаа хийж ажиллана.	300.0	Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр өрөөг бэлдсэн байгууллагын тоо	Эрүүл мэндийн байгууллага-2 Аж ахуйн нэгж байгууллага-1	Эрүүл мэндийн байгууллага-2 Аж ахуйн нэгж байгууллага-2	2025 оныг Дархан-Уул аймгийн Засаг Даргын захирамжийн дагуу “Хүүхэд хамгааллын жил” болгож зарласантай холбогдуулан төрийн болон хувийн хэвшлийн 36 байгууллагад хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх 5 сарын нөлөөллийн аяныг зарлаж аргазүйгээр ханган ажилласан ба 7 байгууллага материал ирүүлсэнээс 2 байгууллага ОБГ, Госхот ӨЭМТ шалгарсан .	100%
1.5.5	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр анхан шатны нэгжүүдэд дэмжлэгт хяналт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	200.0	Дэмжлэгт хяналт хийсэн байгууллага	8	9	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 сарын 03-ны өдрийн Менингококкт халдварын бэлэн байдал, эмчилгээ, оношлогоо, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай албан даалгаврын хүрээнд Нэгдсэн эмнэлэг, 5 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналт хийсэн. Дэмжлэгт хяналтаар нэгжүүдэд 6 чиглэлээр зөвлөмжийг хүргэж менингококкт халдварын бэлтгэл, бэлэн байдлыг хангасан. ХӨСҮТ-ээс 2025.04.06-ны өдрийн ирүүлсэн удирдамжийн дагуу Эрүүл мэндийн газраас 6 хүний бүрэлдэхүүнтэй баг Хонгор, Орхон, Шарын гол сумын эрүүл мэндийн төвүүдийн ХПВ-ын эсрэг вакцины дэмжлэгт хяналт, эрүүл мэндийн ажилтны сургалт, эцэг эхтэй уулзах нөлөөллийн ажлуудыг хийсэн. Дэмжлэгт хяналтыг 19 заалт бүхий үнэлгээний хуудсаар дүгнэхэд сумын эрүүл мэндийн	100%

					төвүүд 94.7% үнэлэгдсэн байна. Хүний папиллома вирусийн эсрэг вакцины хамралт Хонгор суманд 71%, Орхон суманд 94%, Шарынгол суманд 84.6% болж нэмэгдсэн. - Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэс, Нийгмийн эрүүл мэндийн төв хамтран 8-н заалтаар 16-н үйл ажиллагааг үнэлэн зөвлөгөө, зөвлөмжийг өгч тайланг Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн салбар холбоо болон сумын эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн. Үйл ажиллагааны биелэлтийн хүрээнд Хонгор сум 92%. Орхон сум 86%, Шарын гол сум 89%-иар үнэлэгдсэн. 5 Өрхийн эрүүл мэндийн төв, 3 сумын эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналтыг 2 удаа хийж ажилласан. Хяналтаар 5 төрлийн шалгуур үзүүлэлтээр 30 хүртэлх оноогоор үнэлэгдсэн. Улаанбурхан өвчний товллын болон нөхөн дархлаажуулалтад хамрагдвал зохих хүүхдийн судалгаа гаргасан эсэх, ХӨСҮТ-ийн судалгаанаас вакцинд хамрагдах хүүхдийн тоон судалгааг бодитой гаргасан эсэх, Дархлаажуулалтын цахим программын бэлэн байдал, эргэмж шивэлтийн хангалттай байдал, Дархлаажуулалтын хүйтэн хэлхээний бэлэн байдал зэрэгт үнэлгээ хийхэд дунджаар 85.5%-ийн үнэлгээтэй гарсан байна. Үүнд: Аминхолбоо ӨЭМТ- 85.6%, Госхот ӨЭМТ-90%, Гэрэлтэй ӨЭМТ-83.3%, Мэдстоб ӨЭМТ-79.0%, Түвшинхолбоо ӨЭМТ-83.3%, Шарын гол СЭМТ-88.3%, Орхон СЭМТ-90%, Хонгор СЭМТ-85.0% тус тус үнэлэгдсэн. Дэмжлэгт хяналтаар илэрсэн зөрчил дутагдалтай талуудад нэгж бүрт зөвлөмж өгч ажилласан.	
--	--	--	--	--	---	--

1.5.6	ОНЭМА-ыг чадавхжуулах сургалт зохион байгуулж арга зүйгээр ханган хамтран ажиллана.	100.0	Бэлтгэгдсэн ОНЭМА-ны тоо	102	150	МСЭМХ-оос бэлтгэсэн ОНУХТ 11 хүн, Орхон, Хонгор, Шарын гол сум олон нийтийн эрүүл мэндийн ажилтан 12 хүнийг бэлтгэсэн. Олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг сүрьеэгийн талаар чадавхжуулах сургалт болон хувь хүний нууцын талаарх сургалтад хамруулсан. ЭМЯ-наас “Жирэмсэн эхчүүдийн бүлгийн хяналтыг сайжруулах” тогтолцоо сургалтыг зохион байгуулж өрхийн эмнэлэг тус бүрт 1 буюу нийт 5 ОНЭМА нэмж бэлтгэсэн. Их дээд сургууль, уул уурхайн коллеж, ЕБС-ийн ахлах бүлгүүдийн дунд 5 удаагийн сургалтаар 130 сургагч багшийг бэлтгэсэн.	100%
-------	---	-------	-----------------------------	-----	-----	---	------

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: 5 зорилт 23 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (96.5%)

2.ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Зорилт 2.1. Эмнэлгийн анхан болон хоёрдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, багцын стандартыг хангуулах үйл ажиллагааг зохион байгуулах

2.1.1	Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийг ханган ажиллахад дэмжиж, гүйцэтгэлд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	100.0	Өрхийн гүйцэтгэлийн гэрээний үнэлгээний хувь	90%	92.5%	Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15 ны А/122 дугаар тушаалын дагуу Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болох журмын дагуу 2025 оны 01 дугаар сарын 25-нд Аймгийн засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилт дунджаар 95.86% үнэлэгдсэн. Үүнд: ГОСХОТ ӨЭМТ 99.77%, Түвшинхолбоо ӨЭМТ 94.53%, МЭДСТОБ ӨЭМТ 86.51%, Аминхолбоо ӨЭМТ 99.65%, Гэрэлтэй ӨЭМТ 98,85% Долоо хоног тутам Өрхийн ЭМТ -ийн даргатай танхимаар болон цахимаар хурал хийж эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар гаргасан хууль эрх зүйн шийдвэр зөвлөмжийг танилцуулан , тусламж үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж зөвлөмж 34	100
-------	--	-------	--	-----	-------	---	-----

						удаа өгч гүйцэтгэлд 12 удаа хяналт тавьж ажилласан. МЭДСТОБ өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Дархан сум 15-р баг/ 2024 онд Хөх үзүүр ХХК 1,834.8 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарсан. Ажлын явц 80%, олгосон санхүүжилт 1,463.6 сая төгрөг буюу 80% байна. Амин холбоо өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөл барилга (Дархан сумын 14-р баг) 2024 онд Нижуна ХХК 1,442.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарсан. Ажлын явц 85%, олгосон санхүүжилт 1,147.3 сая төгрөг буюу 80% байна. МЭДСТОБ өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Дархан сумын 11-р баг/ 2024 онд БЗД ХХК 1,598.8 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарсан. Ажлын явц 90%, олгосон санхүүжилт 1,263.3 сая төгрөг буюу 79% байна. Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Дархан сумын 9-р баг/ 2024 онд Хангай бигэр ХХК 1,601.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарсан. Ажлын явц 95%, олгосон санхүүжилт 1,227.4 сая төгрөг буюу 77% байна.	
2.1.2	Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний багцын хэрэгжилтийг хангаж гүйцэтгэлд дэмжлэгт хяналт тавин мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	100.0	СЭМТ багцын хэрэгжилтийн хувь	94.0%	95.0 %	Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний багцын хэрэгжилтэд 3 удаа дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. СЭМТ-ийн тусламж үйлчилгээний багцын хэрэгжилт дунджаар 92.1% байна. Сумдын ЭМТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зориолгоор сул орон тоонд ажиллах хүний нөөцийг бүрдүүлэн мэргэжил арга зүйгээр ханган,ажлын байрны сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Шарын гол, Хонгор сумын ЭМТ-д хиймэл оюун ухаанд суурилсан Х-рентген аппаратыг ашиглалтанд оруулсанаар Нэгдсэн эмнэлэгт ирэх урсгалыг 20-25 хувиар бууруулан,бүх сумдын эрүүл мэндийн төв	96.8

						шүдний тусламж үйлчилгээг үзүүлж, Нэгдсэн эмнэлэгт ирэх урсгалыг 40-50 хувиар бууруулан ажиллаж байна. Хонгор сумын ЭМТ-ийн эмнэлэг хүртлэх тусламж яаралтай тусламжийн бэлэн байдлыг сайжруулах зориолгоор АИТХ БНСУ-ын Кенги аймгийн хамтын ажиллагааны хүрээнд парк шинэчлэл хийгдсэн.	
2.1.3	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмнэл зүйн лабораторийн тусламж үйлчилгээг чанарын гадаад хяналтад хамруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	-	Чанарын гадаад хяналтад хамрагдсан лабораторийн тоо	1	7	ЭМС-ын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/485 дугаар тушаалын дагуу Prevecal олон улсын чанарын гадаад хяналтад хамрагдаж буй 5 эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн эмнэлэг MEQAS олон улсын чанарын гадаад хяналтад хамрагдсан 1 байгууллага байна . Эрүүл мэндийн лабораторийн Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулах гадаад үнэлгээний дагуу Цусны шинжилгээг УНТЭ, Биохимийн шинжилгээг УГТЭ ,Бактериологи ХӨСҮТ , аймаг сум өрхийн эрүүл мэндийн төвийн болон хувийн лабораторийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээг Нэгдсэн эмнэлгийн лабораторит хийсэн. Гадаад хяналтад нийт 6 байгууллага хамрагдсан байна	85.7
2.1.4	Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангаж эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхэд мэргэжил арга зүй дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана.	100.0	НЭ стандартын хэрэгжилтийн хувь	НЭ стандартын хэрэгжилтийн хувь 94.0%	НЭ стандартын хэрэгжилтийн хувь 96% Хүүхэд өсвөр үеийн	Эмнэлгийн дэмжих үйлчилгээнд эмнэлгийн хоол үйлдвэрлэлийн нэгжийг байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн. Нэгдсэн эмнэлгийн аюултай хог хаягдалыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар устгуулах гэрээ байгуулан ажиллаж байна. ЭМЯ болон Мэргэжлийн нийгэмлэг холбоотой хамтран улсын хэмжээний нарийн мэргэжлийн эмч нарыг хамруулсан 4 удаагийн сургалтыг Нэгдсэн эмнэлэгт түшиглэн зохион байгуулан нийт 150 гаруй эмч мэргэжилтэн	97.9

					кабинет ажиллуула х	оролцсон. Нэгдсэн эмнэлэгт Эрүү нүүрний мэс заслын тусламж үйлчилгээг амбулатори, хэвтүүлэн эмчлэх мэс заслын тусламж үзүүлэх тоног төхөөрөмжөөр ханган эмнэлгийн тусламжийн төрлийг нэмэгдүүлэн ажиллаж байна. ЭМС-ын тушаалаар батлагдсан төвлөрлийг сааруулах “Хавдрын үндэсний баг”ийн элэг цөс нойр булчирхайн мэс заслын эмч, НЭ-ийн мэс заслын багтай хамтран баруун элэг тайрах мэс заслыг амжилттай хийсэн. -ЭМЯ-наас бөөр шээсний замын мэс заслын тусламж үйлчилгээний төвлөрлийг бууруулах, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн багийхан Нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдтэй бөөр шээсний дээд замын чулуужих өвчний дурангийн мэс заслыг 5 хүнд хийсэн. Австрали, Болгар улсаас ирсэн “Ивэрхийн олон улсын сан”-ын эмч нар болон Улсын 2-р төв эмнэлгийн мэс заслын тасгийн эмч нар хамтран аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нарт “Ивэрхийн мэс засал эмчилгээний олон улсын сургалт” явуулж, 23 иргэнд мэс заслийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Нэгдсэн эмнэлэгт Хүүхэд өсвөр үе, Ахмад, Эрэгтэйчүүдийн кабинетыг нээн тусламж үйлчилгээ үзүүлж байна. НЭ стандартын хэрэгжилтийн хувь 94.1%.	
2.1.5	“Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг”-т хүн амыг хамруулах үйл ажиллагааг идэвхижүүлж, албан хаагчдыг хамруулахад ажил олгогчид болон салбар	300.0	-Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо, хувь	10.5%	Хүн амын 10-аас доошгүй хувийг хамруулах	2025 оны 11 сарын байдлаар нийт 0-17 насны 13883 буюу 36.8%, 18 дээш насны 5065 хүн буюу 7.6% буюу нийт 18950 иргэн буюу дунджаар 18.6% хамрагдсан байна. 2022-2025 онд өсгөнөөр эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт 0-17 насны хүүхэд 85.1%, 18 дээш насны хамрагдалт 49.7%-тай байна.	100

	дундын хамтын ажиллагааг ханган ажиллана.					Үр дүн: 2025 онд хүн амын 18.6% нь урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт хамрагдсан байна. Геронтологийн төв, Настны эмгэг судлалын нийгэмлэг, Нэгдсэн эмнэлэг, Өрх сумын эрүүл мэндийн төв, Ахмадын хөгжлийн төв хамтран 256 ахмад настанд ICOPE буюу эрүүл мэндийн цогц үнэлгээ хийсэн. ЕБС-ийн 1 дүгээр ангийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2603 суралцагчдаас 2588 сурагчид хамрагдаж нийт хамрагдалт 99.42%-тай. Өөрчлөлт илэрсэн 2117 (81.33%), эрүүлжилт 1983 буюу 76.62%-тай байна. АИХТ-ийн санаачилгаар “Эх оронч Дарханчууд” нөлөөллийн аяны хүрээнд ЕБ-н 27 сургууль, Политехникийн 3-н коллежийн 17, 18 настай 936 эрэгтэй суралцагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. “Эрүүл Шүд” арга хэмжээний хүрээнд ЭМГ, НЭ ӨЭМТ,СЭМТ, Хувийн хэвшлийн 18 шүдний эмнэлэг хамтран “24/3-Шүдээ зөв угаа - 2025” аян зохион байгуулж 1 дүгээр ангийн нийт 2544 суралцагч хамрагдсан ба 2201 суралцагч буюу 86.5% шүдний цоорол эзэлж байна. Шүдний гажигтай хүүхдийн тоо 654 буюу 26%-ийг тус тус эзэлж байна. Эмчлүүлсэн 1843 буюу 72.4%-ийг эзэлж байна. Хэрэхийн гаралтай зүрхний өвчин, стрептококкийн гаралтай фарингит өвчнийг оношлох 6-17 насны хүүхдийн үзлэгт хамрагдсан 24718 хүүхдүүдээс 2245 (9%) хүүхдэд өвчлөл илэрсэн. Эерэг илэрсэн 2245 хүүхдэд ЗЦБ хийж, 397 хүүхдэд УГТЭ-н зүрхний эмч	
--	---	--	--	--	--	---	--

						зүрхний эхо оношилгоо хийж, эмчилгээ зөвөлгөө өгч ажилласан. “Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжье” 7 хоногийн аяны хүрээнд ЭМГ, НЭ, СӨЭМТ-д ажиллаж буй 102 эрэгтэй арбан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.	
2.1.6	Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	1,000.0	Хамрагдсан хүн ам	1321	1500	АЗДТГ, ЦГ, ОБГ, ЭМГ, НЭ, СЭМТ, ӨЭМТ хамтран алслагдсан хөдөөгийн малчин иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг ойртуулах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоог 2 удаа зохион байгуулан Явуулын амбулаториор хөдөөгийн алслагдсан хүн амд эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээг нийт 163 айл өрхийн давхардсан тоогоор 1487 хүн үзэж эрүүл мэндийн зөвөлгөө өгч ажилласан. 68 хүнд зүрхний цахилгаан бичлэг, 160 хүнд түргэвчилсэн оношлуураар сахар, холестерин, 21 хүнд тестээр В, С илрүүлэх шинжилгээ хийсэн. Илэрсэн өвчлөл 133. Хэвтэж эмчлүүлэх шаардлагатай 7 ахмад настанг Уламжлалтын тасагт хэвтэн эмчлүүлсэн.	99.1
2.1.7	Анхан шатны тусламж үйлчилгээнд МонПЭН, Халдварт бус өвчин, зүрх судас, чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулан үр дүнг тооцож ажиллахад мэргэжил арга зүй дэмжлэгт хяналтаар хангаж ажиллана.	200.0	Хамрагдсан хүний тоо, хувь	72%	75%	Монпен эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь: Артерийн даралт өвчний эрт илрүүлэг үзлэгт 66082 хүн хамрагдахаас 59028 хамрагдаж хамралтын хувь 89.3% үүнээс артерийн даралттай 443 буюу 0.8%, онош батлагдсан 132 буюу 0.2% байна. Чихрийн шижин 2 эрт илрүүлэг үзлэгт 50218 хүн хамрагдахаас 49434 хамрагдаж 98.4% хамрагдалтай. Үүнээс өөрчлөлттэй 127 буюу 0.3%, чихрийн шижин батлагдсан 22 хүн байна. Халдварт бус өвчин, зүрх судас, чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх	100

						сургалт, сурталчилгааг 15423 хүнд хүргэж ажилласан байна.	
2.1.8	Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын үйл ажиллагааг идэвхижүүлж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүн бэлдэхэд дэмжиж ажиллана.	-	Цус цусан бүтээгдэхүүн	859 нэгж цус, сийвэн бэлтгэсэн	Шаардлагатай тохиолдлын тоогоор	Суурин хэлбэрээр бүхэл цусны цуглуулалт 820 нэгж цус цуглуулсан. 2 удаагийн явуулын цус цуглуулалтаар 51 нэгж цус цуглуулсан. Шинжилгээгээр хасагдсан 2. Аферезийн аппаратаар сийвэнгийн цуглуулалт 25 донороос 73 нэгж сийвэн цуглуулж нөөц бүрдүүлсэн.	100
Зорилт 2.2. Эмнэлгийн тусламж үйчилгээнд оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, дэвшилтэт технологийг нутагшуулах ажиллагааг зохион байгуулах							
2.2.1	Оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, дэвшилтэт технологийг нутагшуулахад дэмжиж ажиллана.	5,000.0	Дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн байдал	Нэвтрүүлсэн шинэ технологи 4	Нэвтрүүлсэн шинэ технологи -1	Гематологийн XN-550 төхөөрөмж суурилуулагдсанаар залуу улаан эсүүд, болон хавдрын эсийг илрүүлэх боломж бүрдэж, биеийн шингэн дэх эсийг тоолох арга нэвтэрсэн. Гематологийн шинжилгээний үзүүлэлт 41 болж нэмэгдсэн. Хэт авиан шинжилгээнд MSK нэвтрүүлэх явцыг эрчимжүүлж 35 хүнд гэмтлийн шалтгаантай дээд доод мөчдийн хэт авиан шинжилгээг хийж, үүнээс шөрмөсний урагдал 24, гематом үүсэн 11 тохиолдлыг амжилттай оношилсон. 10 тохиолдол дээр КТ оношилгооны оронд хэт авиан Doppler тавьж хатгалт хийж, мэдээ алдуулалт амжилттай хийсэн. Дурангийн оношилгоонд орсон 30 тохиолдолд биопси шинжилгээ авсан. 25 хүнд ходоодны ургацаг авсан. Endoscopic Retrograde Cholangiopancreatography (ERCP) шинжилгээ ажилбарыг орон нутагт амжилттай нэвтрүүлж эмчилгээнд 12 үйлчлүүлэгч хамрагдсан. 15 хүн ходоод тайрагдах хагалгаанд орж, 9 хүн ESD хавдар хуулах хагалгаанд орсон.	100

					Дурангаар өрц болон цавины эвэрхий нөхөх мэс засал- 16 -Эмэгтэйчүүдийн хэвлийн хөндийн дурангийн хагалгааг нэвтрүүлж, хамрагдсан үйлчлүүлэгч 12 -Бөөр шээсний замын чулууг дурангаар авах мэс заслын амжилттай нэвтрүүлсэн. Хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо 10. -НЭ-ийн мэс заслын тасаг, ЭМЯ-ны хавдар хими эмчилгээний Үндэсний багтай хамтран орон нутагт элэг тайрах хагалгааг амжилттай хийсэн. Хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо- 2. Үүнд хавдартай элэг тайрах мэс засал-1, 50% тархалттай том хэмжээний элэгний бэтэг тайрах мэс засал-1 -Пренаталь оношилгооны ургийн гажгийг эрт илрүүлэх хоёрол, гурвал тестийг эмнэлзүйн лабораторийн тасагт амжилттай нэвтрүүлсэн. . Үйлчлүүлсэн хүний тоо 31 Интер мед эмнэлэг тодосгогч бүхий MRI аппаратаар нийт шинжилгээ-962, Хүүхдийн зүрхний эхо-254, Хөлийн судасны бүдүүрэлийг оношлох ЭХО шинжилгээ-211, Бамбайн эсийн шинжилгээ, Хөхний эдийн шинжилгээ -38 хийсэн байна. NIPT-ургийн хромсомын гажиг,хүйс тодорхойлох шинжилгээ /BRCA1/2-Хавдрын генийн мутаци тодорхойлох болон Лавалгаа шатлалын эмнэлэгт хийгдэх HBV DNA,HCV RNA,HDV RNA,HCV genotype,HLA-B-27 genotype,STD-7,HPV High risk 14 зэрэг 7 төрлийн Иммунологийн шинжилгээ 20 нэр төрлийн шинжилгээ хийгдсэнээр иргэдийн Улаанбаатар хот руу явах урсгалыг багасгаж ,орон нутагтаа хавдрын болон бусад эмгэгийг эрт үед нь оношлох эмчлэх,боломжийг бүрдүүлэн ажиллаж	
--	--	--	--	--	--	--

						байна. Мөн харшлын 54 төрлийн панел шинжилгээ хийснээр ЭМБ-уудын төвлөрлийг сааруулах, эмнэлгийн тусгай зөвшөөрөлд тусламж үйлчилгээг өргөжүүлэх хэлбэрээр оруулан дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Алтан эх эмнэлэг AI технологид суурилсан бүрэн автомат Samsung Medison Ultrasound HERA Z20 загварын эхо аппаратыг суурилуулсан. Ургийн гажигыг эхийн хэвлийд оношлох 10-12 долоо хоног дотор цусанд В-HCG.PAPP-A уургийг илрүүлэх шинжилгээ, ЭХО-д 12-13.6 долоо хоног дотор NT NB DV TR UA тодорхойлох шинжилгээ хийгдсэнээр иргэдийн хувьд орон нутагтаа оношлуулах боломжийг бүрдүүлсэн байна	
2.2.2.	Нэгдсэн эмнэлэг Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллага болно.	1,000.0	-Сургалт эрхлэх зөвшөөрөл авсан байх, Суралцагчийн тоо	- Зөвшөөрөл авах бэлтгэл 75%	Хэрэгжилт 100%	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 тоот тушаалын дагуу төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөл шинээр хүссэн байгууллагын үнэлгээний 17 шалгуур үзүүлэлтийн дагуу бэлтгэл ажлыг хангаж өөрийн үнэлгээгээр 96% -тай ЭМХТөвийн сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагааны зохицуулалт, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд материалаа албан бичгээр 2025.02.14 нд хүргүүлсэн. "Ерөнхий мэргэшил судлал" үндсэн мэргэшлийн сургалтыг ЭМС-ын 2020 оны А/226 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулах тус эмнэлгийн эмч, сувилагч, сургалтын албаны мэргэжилтэнг Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран 2023-2024 онд үе шаттай бэлтгэж эмнэлзүйн сургагч багш нарыг бэлтгэсэн. Нэгдсэн эмнэлгийн даргын 2024 оны 12 сарын 02-ны өдрийн А/116 тоот тушаалаар 15 хүний бүрэлдэхүүнтэй сүлжээ эмнэлгийн эмч нар, АШУҮИС-н Дархан-Уул аймаг дахь салбар АУС-н багш эрдэмтдийн төлөөлөл оролцуулан "Сургалтын	50

						хяналтын зөвлөл"-ийг байгуулсан. 2025 оны 01 сарын 03 ны өдрийн анхдугаар хурлаар төгсөлтийн дараах 2025-2026 оны хичээлийн жилд "Ерөнхий мэргэшил судлал" үндсэн мэргэшлийн сургалтын дотрын анагаах ухаан судлал, хүүхэд судлал, яаралтай тусламж судлал, эх барих, эмэгтэйчүүдийн судлал, тойролтын ерөнхий хуваарь, сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Хэрэгжилтийн явц: 2025 оны 06 сард ЭМХТ-н төлөөлөл НЭ-д ирж газар дээрх бодит байдалтай танилцаж үнэлэлт өгсөн. Одоогоор НЭ-ээс бүрдүүлсэн баримт, материал ЭМХТ-д хянагдаж байна.	
2.2.3	Эх барих эмэгтэйчүүдийн дурангийн хагалгааны төрлийг нэмэгдүүлнэ.	-	-Шинэ хагалгааны төрлийн тоо - Хагалгаанд орсон хүний тоо	-	Гүйцэтгэлээр	Хэвлийн хүрцээр умай авах, үтрээний хүрцээр умай авах, давсаг сойх, хярзан нөхөн сэргээх мэс заслыг хийж, эмэгтэйчүүдийн хагалгаа нийт 78 хүнд хийсэн. Эмэгтэйчүүдийн хэвлийн хөндийн дурангаар хагалгаа хийж эхэлсэн ба хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо 12 Үр дүн: Эмэгтэйчүүдийн дурангийн хагалгааг шинээр нэвтрүүлж ажилласан.	100
2.2.4	Хавдрын бай эмчилгээг нутагшуулна.	200.0	Хамрагдсан хүний тоо	Шинэ ажил	Гүйцэтгэлээр	Хорт хавдрын шинэ тохиолдлын тоо 246. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17 тохиолдлоор буурсан. Хорт хавдрын улмаас нас барсан тохиолдлын тоо 152. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 тохиолдлоор буурсан. Хорт хавдрын шинэ тохиолдол 26.8% эрт үедээ, 73.2% хожуу үедээ оношлогдсон. Одоо 1334 иргэн хавдрын хяналтанд байна. Хөнгөвчлөх тасаг 8 ортойгоор 492 хүнд хөнгөвчлөх эмчилгээ, тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Хавдрын өдрийн бай эмчилгээг 62 хүнд хийсэн. Хавдрын хими эмчилгээг 245 хүнд хийсэн. Эмчилгээний явцад гарсан хүндрэл байхгүй.	100

						ЭМЯ-ны хавдар, хими эмчилгээний Үндэсний багтай хамтран 229 хүнд үзлэг хийснээс элэг цөсний үзлэг-130, хавдрын үзлэг 99, тасагт хими эмчилгээ-6, элэг тайрах мэс засал 1 хүнд тус тус хийсэн. Хавдрын хими эмчилгээний тусламж үйлчилгээг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлэхээр ХСҮТ-д богино хугацааны сургалтанд 4 ажилтан хамруулсан. Үүнд эм найруулагчаар 1, эмзүйч-1, сувилагч-2.	
Зорилт-2.3. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх тогтолцоог бэхжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлэх							
2.3.1	Амь тэнссэн үеийн яаралтай болон түргэн тусламжийн чиглэлээр эрүүл мэндийн ажилтны мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд ажлын байрны болон урт богино хугацааны сургалтыг зохион байгуулж, удирдлага мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	350.0	Сургалта Д хамрагдс ан эмч, мэргэжил тэн	80	100	Дархан-Уул аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс, Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгийн сургагч багш нартай хамтран “Яаралтай тусламжийн үеийн үнэлгээ болон авах арга хэмжээ” сэдэвт сургалтыг ЭМГ, НЭ, СӨЭМТ-үүд, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Улаан загалмайн хорооны нийт 110 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулсан. VAST LTD Австрали, Канад, Англи улсын мэдээгүйжүүлгийн эмч нарын нийгэмлэг, Монголын мэдээгүйжүүлэгч эмч нарын нийгэмлэгээс Дархан Нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагч нарт "VAST" Амин чухал мэдээгүйжүүлгийн загварчилсан 3 хоногийн сургалтыг зохион байгуулсан.	100
2.3.2	Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх, яаралтай , суурь тусламжийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлэхэд холбогдох мэргэжлийн холбоо Төрийн болон ТББ	200.0	Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан	40	50	Дархан-уул аймгийн ГХГСОТБСС-ийн санхүүжилтээр олон нийтийн сайн дурын идвэхтэн бэлтгэх сургалтыг Монголын яаралтай тусламжын нийгэмлэгтэй хамтран 28 төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгжийн 70 сайн дурын идэвхтэн сургагч багш бэлтгэж, НЭМТ,ЭМГ ,Өрхийн ЭМТ,Сумын ЭМТ-ийн их эмч ,сувилагч ,жолооч 30 ажилтанд хөлдөлт осголт,яаралтай амилуулах суурь тусламжийн ур	100

	байгууллагатай хамтран ажиллана.					чадварыг олгох сургалтыг Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасагтай хамтран зохион байгуулсан байна. Дархан Өргөө политехникийн коллежийн оюутнуудад Амилуулах суурь тусламжийн анхан шатны мэдлэг олгох онол, гардан хосолсон сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 98 оюутан хамрагдсан.	
2.3.3	Симуляци сургалтын төвд Нэгдсэн эмнэлгийн эмнэл зүйн сургагч багш нартай хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтний гардан үйлдлийн чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлэх, СӨБ, ЕБС, үйлдвэр, аж ахуй нэгжийн эмч нарыг хуваарийн дагуу хамруулах ажлыг зохион байгуулна.	200.0	Сургалта д хамрагдсан ЭМА тоо	200	250	Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгийн сургагч багш нартай хамтран Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХХК-ны 12 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд гардан үйлдлийн чадавхжуулах сургалт зохион байгуулж, симуляци сургалтын төвийн үйл ажиллагааг танилцуулсан. Аймгийн ЗДТГ, Нэгдсэн эмнэлэг, АШУҮИС, ХАТТАН Миллиниум RDS, ICNA олон улсын байгууллага хамтран “Нярайд амьдрал бэлэглэе-2” улсын хэмжээний 3 өдрийн сургалтыг зохион байгуулж 21 аймаг, нийслэлийн амаржих газруудаас нийт 50 гаруй төлөөлөл оролцож АНУ болон Монголын доктор профессорууд сургалтыг удирдан явуулсан. “Амилуулах болон лавшруулах суурь тусламж үйлчилгээ” онол , дадлагын сургалтыг Хүлээн авах яаралтай тусламжийн тасагтай хамтран ӨЭМТ-ийн 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд чадавхжуулах сургалт зохион байгуулсан. “Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандартын хэрэгжилт”ийн түвшин тогтоох мэргэжлийн зөвлөх, тэргүүлэх мэргэжилтний бүрэлдэхүүнтэй комисс гардан үйлдлийн үнэлгээг сувилагч мэргэжилтний дунд зохион байгуулж, чадвахжуулах сургалтыг 8 удаа давхардсан тоогоор 1400 гаруй сувилагч тусгай мэргэжилтэн хамрагдсан байна. Дотоод шүүрэл, дүрс оношилгооны тасгийн	100

						эмч нар, өрхийн дүрс оношлогооны эмч нарт "Бамбайн хэт авиан шинжилгээг чанартай, нарийн техник үзүүлэлтээр хийж гүйцэтгэх нь" сэдэвт онол дадлага хосолсон сургалтыг амжилттай зохион байгуулсан. Н.П.Шастины нэрэмжит УШТЭ-ийн Сувилахуйн алба нь "МЭС ЗАСЛЫН СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ" сэдэвт онол-дадлага хосолсон сургалтыг Нэгдсэн эмнэлгийн сувилагч мэргэжилтэнүүдэд амжилттай зохион байгуулсан.	
Зорилт 2.4. Жирэмсэн эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах							
2.4.1	Жирэмсний эрт үеийн хяналт, хамралтыг сайжруулахад жирэмсний хяналтын чанарыг сайжруулан жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирусийн илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд хяналт тавихад мэргэжил арга зүй дэмжлэгт удирдлагаар ханган ажиллана.	-	Эрт хамралтын хувь	94.5%	95%	2025 оны 11 сарын байдлаар Жирэмсний хяналтанд 1645 эх орсноос 0-3 сартай 1583 буюу 96.2%, 4-6 сартай 54 буюу 3.2%, 7 сартай 8 буюу 0.4% байна. Жирэмсний хяналт, үзлэгийг хамрагдалтыг сайжруулах зорилгоор ЭМГ 2025 оны хагас жилийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлтийн танилцууллага 1 удаа , ЭМС-ын А/292 тоот тушаал "Эх,хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд " арга хэмжээний төлөвлөгөө 2025-2028 он боловсруулан ЭМГ даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЭМГ-ын 3-р улирлын хяналт шинжилгээ үнэлгээгээр Төрөх тасгийн зөвлөх эмч өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн жирэмсний хяналт, жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирусийн илрүүлэг шинжилгээний хамрагдалтад үнэлгээ хийж, мэргэжил аргагүйгээр хангаж ажилласан.	100

2.4.2	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч мэргэжилтний мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд (эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр) Нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллана.	-	Хамтран ажилласан байгууллага, хамрагдсан ЭМА	Байгууллага-3 ЭМА-8	Байгууллага-1 ЭМА-16	ЭМГ-ын даргын зөвлөлийн хурлаар аймгийн эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал тулгамдсан асуудлыг хэлэлцсэн. Өрх, сумын ЭМТ, Нэгдсэн эмнэлгийн эх баригч 28 мэргэжилтэнд чадвахижуулах сургалт зохион байгуулан ,ЭМС 219, 264 дүгээр тушаалыг танилцуулсан. Орхон аймгийн ЭМГ, ӨЭМТ,Нэгдсэн эмнэлгийн эх барих жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын сайн туршлага судлахад 34 мэргэжилтэнг хамруулсан.	100
Зорилт 2.5. Хүүхэд, нярайн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, бага насны хүүхдийн суурь өвчин, гүйлсэн булчирхайн эмгэгийг эмчлэх тусламж үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах							
2.5.1	Хүүхэд, нярай ,өсвөр үеийнхний дунд зонхилон тохиолдлох өвчлөл, нас баралтад судалгаа хийж, сэргийлж болох нас баралтыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.	-	Судалгааны дүн мэдээ	Судалгаа 1	Судалгаа 1	Хүүхдийн өвчлөл, нас баралтын статистик үзүүлэлтэд судалгаа, дүн шинжилгээ хийж ажилласан. Амбулаторийн өвчлөл 0-5 насанд 2024 онд 46,3 байсан бол 2025 оны 11 сарын байдлаар 45,9%-тай байна. Өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд Амьсгалын өвчин 63.3, ХБЭ 11.4, Арьс 7.0, Нүдний эмгэг 4.8, чихний эмгэг 4.6 хувь тус тус эзэлж байна. Стационарын өвчлөл 1-5 насанд 60.2% байгаа нь урьд оноос 2.7%-иар нэмэгдсэн байна. Стационарын өвчлөлд: Амьсгалын өвчин 57.8, ХБЭ 45.5, Перинаталь үед үүссэн зарим эмгэг 6.6, Мэдрэлийн эмгэг 4.6, осол гэмтэл 3.2% эзэлж байна. Нас баралт: 0-15 насны нас баралт 27 гарсан нь урьд оноос 8 тохиолдлоор нэмэгдсэн байна.0-1 насны нас баралт 18 гарсан нь урьд оноос 6 тохиолдлоор нэмэгдсэн.1-5 насны хүүхдийн нас баралт 5 гарсан нь урьд оноос 2 тохиолдлоор бууурсан үзүүлэлттэй байна. Нэгдсэн эмнэлгийн нярайн тасгаас төрсөн эх, хүүхдийг өрхийн эмнэлгийн хяналтад гараас гарт картик үйлчилгээ нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн хүүхдийн тасгаас эмчлүүлэн гарч байгаа хүүхэд бүрийг харъяа өрхийн эмнэлгүүдэд нь цахим хаяг нээж хүлээлгэн өгч байна.	100

						2026 онд Ургийн цахилгаан бичлэгийг 5 өрхөд ажиллуулахар 40 сая төгрөгний төсөв, НЭҮНШТҮ тоног төхөөрөмж авахаар 109 сая төгрөгийг орон нутгийн төсөвт суулгасан.	
2.5.2	9, 18, 36 сартай хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчлөл илэрсэн хүүхдүүдийг эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүй дэмжлэгт удирдлагаар ханган ажиллана.	-	- Хамрагдсан хүүхдийн тоо	4300	2500	-9,18,36 сартай хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллан нийт 5 ӨЭМТ, СЭМТ-д 9, 18, 36 сартай нийт 2500 хүүхэд хамрагдвал зохихоос 2541 хүүхэд буюу 100% эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдсан. -ЭМГ-ийн ЭТҮХ-ийн хүүхдийн ерөнхий мэргэжилтэн НЭ-ийн хүүхдийн тасгийн эмч нартай хамтран 3 сум, 5 ӨЭМТ-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, эмнэлгийн тусламж авч чаддаггүй зорилтот бүлгийн хүүхдүүдэд “Хүүхдийн эмчийн өдөрлөг” зохион байгуулж 300 гаруй хүүхдэд үзлэг хийж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	100
2.5.3	Шинэчилсэн ХӨЦМ болон олон нийтэд суурилсан ХӨЦМ-ийн сургалт зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр хангаж, ХӨЦМ-ийн тандалт, үнэлгээ хийж ажиллана.	200.0	- сургалтад хамрагдсан эмч тусгай мэргэжил тнүүдийн тоо - сургалтад хамрагдсан эцэг эхчүүдийн тоо	Эцэг эх- 933 Эмч, мэргэжилтэн-86	500 эцэг эх Эмч мэргэжилтэн-60	Өрх сумын ЭМТ-ийн эмч нар болон хүүхдийн тасгийн эмч, хувийн эмнэлгийн эмч нарт “Хүүхдийн өвчний цогц менежмент ,Хүүхдийн зонхилон тохиолдох эмгэгүүд , Хүүхдийн мэдрэл сэтгэцийн эмгэгүүд” сэдвүүдээр АШУҮИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхимийн багш АУ-ны доктор М.Энхзол, Монголын хүүхдийн анагаахын Академийн тэргүүн Д.Амгалан нар онол, дадлага хосолсон хэлбэрээр танхимын сургалт зохион байгуулж 73 эмч хамрагдсан байна. ХӨЦМ-н сургалтыг Өрх, Сумын ЭМТ-д нийт 8 удаагийн сургалтаар 485 эцэг эх хамрагдсан байна. ЭМГ-аас ХӨЦМ-ийн тандалтыг 5 өрх, 3 сумын ЭМТ-д зохион байгуулж дундаж үнэлгээ 90.8% байна .	100

2.5.4	Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. Үүнд: • Ургийн гажгийн эрт илрүүлэг • Нярайн эрт илрүүлэг(түнх, зулайн эхо, сонсгол, нүдний скрининг) • Сургуульд суурилсан 6 настай хүүхдийн эрт илрүүлэг	-	Үзлэгт хамрагдсан хүүхэд	Нярайн эрт илрүүлэг 1669	2000	2025.09 сард нярай судлалын 2 эмчийг ЭМЯ-ны нярайн скринингийн сургалтад хүний нөөцийг сургаж бэлтгэсэн. 2025.10.01 өдрөөс эхлэн Монгол улс даяар гүйцэт нярайн 6 төрлийн, дутуу нярайн 7 төрлийн скрининг шинжилгээг хийж эхлэх ЭМЯ-ны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан. Зүрхний гажиг эрт илрүүлэг скрининг - 168 - Сонсголын скрининг - 168 - Нүдний скрининг - 168 - Зулай ЭХО - 152 - Түнхний ЭХО нийт 1542 нярайд хийгдсэн байна. СРАР аппаратыг 1 ширхэг авч нярайн тусламж үйлчилгээнд ашигласан. СРАР аппаратанд эмчлүүлсэн хүүхдийн тоо- 27. Пренаталь оношилгооны ургийн гажгийг эрт илрүүлэх хоёрол, гурвал тестийг эмнэлзүйн лабораторийн тасагт амжилттай нэвтрүүлж 31 жирэмсэн эмэгтэйд жирэмсний 11-12 долоо хоногтойд дауны синдром, эдвардсын синдром, патаугийн синдромын эрсдлийг үнэлэх тестүүд хийгдсэн. Сургуульд суурилсан 6 настай хүүхдийн эрт илрүүлэг үзлэгт ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн нийт 2603 суралцагчдыг хамруулахаас 2588 сурагчид хамрагдаж нийт хамрагдалт 99.42%-тай байлаа. Үүнээс өөрчлөлттэй 2117 (81.33%), эмчлүүлсэн 1983 буюу 76.62%-тай байна. Үр дүн: Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт 4145 хүүхэд хамрагдсан байна.	100
2.5.5	Нэгдсэн эмнэлгийн Өсвөр үеийн кабинетийн үйл ажиллагааг тогтмолжуулна.	-	-Тусламж үйлчилгээ авсан хүүхдийн тоо	-	Гүйцэтгэл ээр	Эрүүл Мэндийн Сайдын 2024 оны 12-р сарын 12-ы өдрийн А/504 тоот тушаал “Өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний журам”-н хэрэгжилтийн хүрээнд “Өсвөр үеийн кабинет”-ийг 2024 онд байгуулан 2025 онд үйл ажиллагааг эрчимжүүлэн 1 эмч, 1 эх баригч бүрэлдэхүүнтэй	100

						нээсэн. Хамтран ажиллах эмч нарыг тушаалаар баталгаажуулсан. ЭМ-ийн үзлэг, үйлчилгээ авсан үйлчлүүлэгч-192 Өсвөр үеийнхэнд зонхилон тохиолддог халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох 10 удаагийн сургалтад 435 сурагчийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй өсвөр үеийнхэнд чиглэсэн сургалт үйл ажиллагаанд 70 сурагч хамруулсан Шинээр “Үе тэнгийн сургагч” багш бэлтгэх сургалтыг ЭМГ Өсвөрийн үеийн кабинеттэй хамтарч ЕБС-ын 8-11 дүгээр ангийнханд эрүүл мэндийн болон эрсдэлээс урьдчилан сэргийлэх “Үе тэнгийн-ээрэг нөлөөлөгч” сургагч багш бэлтгэх тусгай хөтөлбөрийг бэлтгэн 280 хүүхдийг хамруулсан.	
Зорилт 2.6. Уламжлалт анагаах ухаан, хөнгөвчлөх, сэргээн засах, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах							
2.6.1	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг өргөжүүлэн, хүний нөөцийг чадавхжуулахад мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	-	- Сургалтад хамрагдсан ажилтны тоо -Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	Сургалтад хамрагдсан ажилтан 23 - Тусламж үйлчилгээ авсан иргэд 889	Сургалтад хамрагдах ажилтан 5 -Тусламж үйлчилгээ тохиолдлын тоогоор	Олон улсын эмч нарын өдрийг тохиолдуудан хийсэн онол практикийн бага хуралд Зочин илтгэлээр Нэгдсэн эмнэлгийн уламжлалтын тасгийн их эмч Ө.Солонго АЗЦХ -ын үед уламжлалт эмийн хэрэглээ үр дүнг танилцуулсан. 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр болсон УАУ эрдмийн чуулганд Нэгдсэн эмнэлэг болон хувийн хэвшлийн 4 их эмч оролцсон. Нэгдсэн эмнэлгийн уламжлалтын тасгаар 658 гаруй иргэн үйлчлүүлж 349 хүн хэвтэн эмчлүүлсэн байна. Хэвтэн эмчлэх тасгийн орчин нөхцлийг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын хөрөнгө оруулалтаар 8 өрөөнд бүрэн засвар хийсэн. Эмч мэргэжилтэн хүний нөөцийг чадвахижуулах зориолгоор БНХАУ-д 1 их эмч 5 сувилагч мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан. "Дархан-Алтан тун 2025" Уламжлалт анагаах ухааны өдөрлөгийг зохион байгуулж 33 байгууллага хамтран оролцож, 250 иргэнд мэдээлэл, сурталчилгаа үзүүлсэн байна.	100

						Үр дүн: Сургалтад 9 эмч хамрагдаж, , 250 иргэнд мэдээлэл, сурталчилгаа өгч, уламжлалт анагаах ,ахмадын тасгаар 658 гаруй иргэн үйлчлүүлсэн байна.	
2.6.2	Хөнгөвчлөх, хими эмчилгээний тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	-	-Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо - Сургалта д хамрагдсан хүний нөөц	- Хэвтэн эмчлүүлсэн 438 үйлчлүүлэгч - Сургалтад хамрагдсан хүний нөөц-31	- Тусламж үйлчилгээ авсан иргэдийн гүйцэтгэлээр - Сургалтад хамрагдсан хүний нөөц 35	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд 1148 хүн хамрагдсан. Хөнгөвчлөх тасаг 8 ортойгоор 492 хүнд хөнгөвчлөх хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. - ХСҮТ-д хими эмчилгээний тасагт 2 сувилагчийг ажлын байрны 14 хоногийн сургалтанд хамруулсан. - ХСҮТ-д “Хавдрын төрөлжсөн сувилахуйн тусламж үйлчилгээ” сэдэвт 3 өдрийн сургалтад 5 ажилтан хамрагдсан. “Хорт хавдрын хими эмчилгээний үеийн сувилахуйн тусламжийн заавар”, “Химийн эмчилгээний эм найруулах, эмийн хэрэглээ заалтууд” сэдэвт сургалтыг 9 хүн хамрагдсан. Сургалтын өмнөх сорил 46%, сургалтын дараах сорил 83.2% буюу 37.2% ахисан үзүүлэлттэй байна. - Өдөрлөг 1 удаа зохион байгуулж, өрх сумын 24 эмнэлгийн мэргэжилтэнд мэдээлэл хүргэж, 150 гаруй иргэнд зөвлөгөө, сурталчилгаа өгч ажилласан. Үр дүн: Хөнгөвчлөх тусламж үйлчилгээг нийт 1148 хүн хамрагдаж, 492 хүн хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ үзүүлсэнд хамрагдсан. Хүний нөөцийн чадавхижуулах сургалтад 40 ажилтан хамрагдсан байна.	100
2.6.3	Өрх болон сумын сувилахуйн тусламж үйлчилгээний гардан үйлдлийн стандартын хэрэгжилтийг үнэлж, үр дүнг тооцон , сургалт зохион байгуулах, тусламж, үйлчилгээний чанар,	300.0	Сургалта д хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо,	Сургалтад хамрагдсан 493 сувилагч	- Сургалтад 500 эмнэлгийн мэргэжилтэн	Сувилахуйн тусламж, үйлчилгээний гардан үйлдлийн сургалтыг Тарилгын аюулгүй байдал, Эрт сэрэмжлүүлэг хийх аргачлал, Сорил тавих техник, Шинжилгээнд сорьц авах, тээвэрлэх, Уян зүү тавих, хянах арга техник, Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, Амь тэнссэн үеийн яаралтай тусламж, Холголт, цооролтын үеийн асаргаа, сувилгаа зэрэг 8 сэдвээр 15 удаа зохион байгуулж, 350 гаруй сувилагч,	95

	хүртээмжийг сайжруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана .		үнэлгээний хувь	- Сургалтын дараах мэдлэг 85.6% - Гардан үйлдлийн стандартын хэрэгжилт 89%	-Гардан үйлдлийн стандартын хэрэгжилт 90%	эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан. Сургалтын өмнөх мэдлэг 78%-тай байсан бол сургалтын дараа 84% буюу 6%-иар өссөн байна. Сувилахуйн эмнэлзүйн ур чадварын төвд Нэгдсэн эмнэлэг, Бид, Энх-уламжлал, Цээнэ, Хангай клиник, Саран-Элит, Орхон, Хонгор, Шарын голын сумын ЭМТ, Амин холбоо, Гэрэлтэй, МЭДСТОБ ӨЭМТ-ийн 102 сувилагчийг оролцуулан “Амилуулах суурь тусламж, Эрт сэрэмжүүлэг үнэлгээ” сэдэвт сургалт зохион байгуулсан ба 5 туслах сувилагчид “Хүнд өвчтөний асаргаа сувилгаа” сэдвээр сургалтыг зохион байгуулсан. Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандартын хэрэгжилтийн түвшин тогтоох үнэлгээнд Нэгдсэн эмнэлгийн 133 сувилагч хамрагдсанаас: Онол 78%, Бодит үзлэг 82.6%, Яаралтай тусламж, эрэмбэлэн ангилал 86.6%, Тоног төхөөрөмжтэй ажиллах 88%, Гардан үйлдэл 89.4%, Амь тэнссэн үеийн тусламж 86.4% буюу дундаж үнэлгээ 85% байна. Үр дүн: Стандартын сургалтыг 8 сэдвээр 15 удаа зохион байгуулж, 457 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан ба Гардан үйлдлийн үнэлгээ 85%-тай үнэлэгдсэн байна.	
2.6.4	Сувилахуйн дагнасан төвүүдтэй хамтран урт хугацааны тусламж, үйлчилгээний үлгэрчилсэн загварыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.	-	Хамтран ажиллах гэрээ Тусламж үйлчилгээ авсан иргэд	1788	500	Урам өглөө сувилахуйн төв нийт давхардсан тоогоор 2095 хүн, Ивээлт гар сувилахуйн төвөөр нийт 210 хүн үйлчлүүлсэн. Урам өглөө, Ивээлт гар, Итгэл сувилахуйн төвд 1 удаа цахимаар мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. АШУҮИС-ийн Сайхан сэтгэл эмнэлэг тусгай зөвшөөрөлд “Сувилахуйн дагнасан төв” чиглэл нэмэхээр хүсэлт өгч, ажлын хэсэг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, баримт бичиг болон ажлын байранд үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажилласан. Үр дүн: Тусгай зөвшөөрөл авсан 3 сувилахуйн төвийн 2 нь үйл ажиллагаа хэвийн явагдаж давхардсан	100

						тоогоор 2305 хүнд сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	
2.6.5	“Сувилахуйн эмнэлзүйн ур чадварын төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллана.	-	Ур чадварын төвөөр үйлчлүүлсэн сувилагчийн тоо	4 төрлөөр 50 сувилагч	6 төрлөөр 250 сувилагч	Эрүүл мэндийн байгууллагуудын сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг эмнэлзүйн сургалтын төвд сургаж, чадавхжуулах сургалтын удирдамж, хуваарийг боловсруулан, ЭМГ-ын даргаар батлуулж, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна. Сувилахуйн эмнэлзүйн ур чадварын төвд зохион байгуулсан “Амилуулах тусламж”, “Эрт сэрэмжлүүлэг үнэлгээ” сэдэвт дадлага сургалтад 102 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан байна. “Амилуулах болон лавшруулах суурь тусламж үйлчилгээ” онол , дадлагатай сургалтыг яаралтай тусламжийн мэргэшсэн эмч, сувилахуйн албатай хамтран зохион байгуулж ЭМБ-ын нийт 120 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд хамрагдаж, багаараа гардан дадлага хийж чадавхжсан үр дүнтэй байна. Үр дүн: 6 төрлийн сэдвээр сургалт зохион байгуулж, 222 сувилагч хамрагдсан байна.	90
2.6.6	“Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал” /Clinical Ladder/-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.	200.0	Ур чадвар эзэмшсэн сувилагч, мэргэжилтний тоо	100	200	Шинэ сувилагчийг ажлын байранд дадлагажуулан сургах хөтөлбөр “Clinic Leader”-ийг хэрэгжүүлэн 7 сувилагчийг 3 удаагийн сургалтанд хамруулсан. Эрүүл мэндийн яам болон Японы олон улсын хамтын ажиллагааны Жайка байгууллага хамтран “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн хүрээнд “Шинэ сувилагчийн сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулсан ба хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хэсгийг ЭМГ-ын даргын А/124 дүгээр тушаалаар томилж, тус хөтөлбөр төлөвлөгөөний дагуу нийт 78 шинэ сувилагчид “Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, “Сувилагчийн хөгжил, манлайлал” сэдвээр сургалт зохион байгуулсан. Нэгдсэн эмнэлэгт шинээр ажилд орсон 11 сувилагчийг ахлах сувилагч нарт гараас гарт зарчмаар зөвлөмжийн хамт хүлээлгэн өгч	100

						туршилтын 3 сарын хугацаанд үнэлгээний хуудсаар дүгнэж ажлын байран дээр сургаж байна. Гардан үйлдэл, амь тэнссэн үеийн тусламжийн үнэлгээнд 133 сувилагч хамрагдаж, дундаж үнэлгээ 85% байна. Үр дүн: “Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал” /Clinical Ladder/-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн гардан үйлдэл, амь тэнссэн үеийн тусламжийн сургалтад 96, үнэлгээнд 133 сувилагч хамрагдаж, дундаж үнэлгээ 85% байна.	
2.6.7	Сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдлага, манлайллыг бэхжүүлэх, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ЭМС-ын 2024-10-24-ны өдрийн “Дүрэм, чиг үүрэг шинэчлэн батлах тухай” А/424 дүгээр тушаалыг таниулан, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Тушаалын хэрэгжилтийн хувь	20%	80%	Сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдлага, манлайллыг бэхжүүлэх, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ЭМС-ын 2024-10-24-ны өдрийн “Дүрэм, чиг үүрэг шинэчлэн батлах тухай” А/424 дүгээр тушаалыг ЭМГ-ын шуурхай хуралд ЭМБ-уудын удирдлагуудад танилцуулсан. 2021-2025 оны сувилахуй, эх барихуйн стратегийн бодлогын чиглэл, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, тулгамдаж буй асуудал, 2025 оны сувилахуйн үйл ажиллагааны төлөвлөгөө, шинээр гарсан тушаал, заавар, удирдамж танилцуулж, эмнэлзүйн ур чадварын төвийг өргөжүүлэн ажиллах, сувилагчдын ёс зүй болон мэргэжлийн чиглэлээр анхаарч ажиллах талаар зөвлөмж өгч Нэгдсэн эмнэлгийн 30 сувилахуйн албаны дарга, арга зүйч, ахлах сувилагч нар, Өрх, СЭМТ-ийн 9 ахлах сувилагч нар хамрагдсан. Үр дүн: ЭМС-ын 2024-10-24-ны өдрийн “Дүрэм, чиг үүрэг шинэчлэн батлах тухай” А/424 дүгээр тушаалын хэрэгжилт 80%-тай байна.	100
2.6.8	2024 оны шинэ технологийн бүтээлүүдээр үр дүнгийн өдөрлөг хийж, “ Сувилахуйн технологи-2025 ” шинэ бүтээлийн уралдаан зохион байгуулна.	1.500.0	Шинэ бүтээлийн тоо	15	25	“Сувилахуйн технологи-2025” бүтээлийг тасаг бүрээр дүгнэн ажилласан ба Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын сувилахуйн баг тусламж, үйлчилгээнд хэрэгжүүлж буй шинэ 21 технологийг танилцуулан 13 технологийн үр дүнг тооцож, 565 үйлчлүүлэгчид хэрэглэсэн байна.	85

2.6.9	Сэргээн засах тусламж үйлчилгээний эмнэл зүйн зааврын хэрэгжилтийг хангуулах ,сайн туршлага нэвтрүүлэх чиглэлээр эмч эмнэлгийн мэргэжилтэнд ажлын байрны сургалтыг зохион байгуулна	200.0	Сургалта д хамрагдс ан ажилтны тоо	10	60	Сэргээн засах тусламж үйлчилгээг 7 чиглэлээр 23 төрлийн сэргээн засах тусламж үйлчилгээнд давхардсан тоогоор 6208 үйлчлүүлэгч хамрагдсан. Сургалт:JICA-ын сайн дурын гишүүн Япон улсын хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч нар ХБ-тэй 6 хүүхдэд үзлэг оношлогоо хийж, асран хамгаалагчдад нь хөдөлмөр засал, хөдөлгөөн заслын талаар зөвөлгөөг өгсөн. Хөгжлийн бэрхшээлтэй хүний төвтэй хамтарч ажиллах, хүрээнд Сэргээн засах эмчилгээний тухай ойлголт, Хөдөлмөр засал,Хөдөлгөөн засал эмчилгээний тухай сургалтад 45 эмнэлгийн ажилтан хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний төвд сэргээн засах туршлага судалсан 11 ажилтан.	93.3
2.6.10	Осол гэмтэл, цочмог өвчлөлийн дараах нөхөн сэргээх тусламж үйлчилгээний нэр төрлийг ХБИ-ийн төвтэй хамтран эрүүл мэндийн байгууллагад өргөжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	200.0	Шинээр нэвтрүүлс эн нэр төрөл	Шинээр	ЭМБ-ууд	Цочмог өвчлөлийн дараах сэргээн засах тусламж үйлчилгээнд нийт 785 хүн үйлчлүүлсэнээс Цахилгаан эмчилгээ- 121 • Гэрэл эмчилгээ- 158 • Зүү эмчилгээ -87 • Бариа засал эмчилгээ-225 • Бусад эмчилгээ -194 ХБИ-д сэргээн засах тусламж үйлчилгээг 109 үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, хүртээмжтэй үзүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүний төвд 11 эмнэлгийн ажилтан туршлага судалсан. Ахуй засал, ил хатгуурын тусламж үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн.	100
Зорилт 2.7. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулж, үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг үзүүлэх							
2.7.1	Тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжсэн магадлан итгэмжлэл бүхий чанарын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэхэд мэргэжил	-	Чанарын хөгжлийн хөтөлбөр ийн хэрэгжилт хувь	85%	87%	2025 онд магадлан итгэмжлэл сунгах 10 эрүүл мэндийн байгууллагын 22 шаардлага, 14 материалыг ЭМХТ-ийн цахим системд илгээн баталгаажуулах зэрэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн. 2025 онд Магадлан итгэмжлэл үнэлэх шинжээчийн баг 4 удаагийн томилолтоор 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03	100

	арга зүйн болон дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана					сарын 18 –ны өдрийн А/84 дугаар тушаал, 2025 оны 04-р сарын 04-ны А/113 тоот тушаал, 2025 оны 04-р сарын 15-ны өдрийн А/126 тушаал, 2025 оны 10-р сарын 27-ны А/406 тушаалаар 10 эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл 1-3 жилийн хугацаагаар сунгагдан ирсэн. Мөн магадлан итгэмжлэх үнэлгээнд хамрагдсан 7 ЭМБ-ын шинжээчийн зөвлөмжийг ЭМБ-уудад хүргүүлж ЭМС-ын А/112 тушаалын 3-р хавсралтын дагуу “Эрүүл мэндийн байгууллагын, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө” боловсруулах арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 2026 онд магадлан итгэмжлэх үнэлгээнд хамрагдах 9 ЭМБ-д ЭМГ-н даргын удирдамжийн дагуу ЭМС-н А/412 тушаалын шалгуураар явцын үнэлгээг хийж ажиллаж байна.	
2.7.2	Чанарын аян, өдөрлөг зохион байгуулахад удирдлага арга зүй зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажиллана .	200.0	Оролцсон иргэдийн тоо тайлан	3000	3500	Нярай болон хүүхэд бүрд аюулгүй тусламж үйлчилгээ 14 хоногийн аяны хүрээнд “Төрсөн цагаас нь аюулгүй байдалд анхааръя” уриатай ӨДӨРЛӨГИЙН үйл ажиллагааг Нэгдсэн эмнэлэг, Өрх, сумын ЭМТ-д зохион байгуулж 74 хүүхдэд хүүхдийн эмчийн үзлэг хийсэн. Хүүхдийн хооллолтын өдөрлөг, зөвлөгөө, сургалтыг зохион байгуулж эцэг эх, асран хамгаалагч нарт 4 төрлийн хүүхдийн хоол, жимс болон хүнсний ногоог хүүхдэд аюулгүй хэрэглэх зааврыг хүргэж, хоолны амталгааг хийлгэн, 114 хүнд сургалт, 2451 хүнд мэдээлэл хүргэсэн байна. Орон нутгийн RGB, DBS TV-ээр шууд дамжуулан, иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан ба хандалт 5229 байна.	100
2.7.3	Эрүүл мэндийн байгууллагуудаар	300.0	- Судалгаа	85 %	86 %	9 ЭМБ хэрэглэгчийн үнэлгээний QR кодоор амбулаторийн тусламж үйлчилгээ авсан нийт 2848	95

	үйлчлүүлэгчид болон эмч ажилтны сэтгэл ханамжийн судалгааг 1313 мн-ээс цахимаар авч үр дүнг тооцож үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахад мэргэжил арга зүйгээр дэмжлэг үзүүлнэ.		нд оролцсон иргэд, ажилчдын тоо -Иргэдийн сэтгэл ханамжны н хувь			хэрэглэгчээс сэтгэл ханамжийн үнэлгээг цахимаар авахад эмчилгээний үр дүнд иргэдийн 1095 буюу 38.41% маш хангалттай, 1538 буюу 53.95% хангалттай, 185 буюу 6.49% дунд зэрэг, 20 буюу 0.70% огт хангалтгүй гэсэн сэтгэл ханамжийн үнэлгээ өгсөн бол Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ авсан 154 хэрэглэгчээс сэтгэл ханамжийн үнэлгээг авч 25 буюу 16.23% маш сайн, 88 буюу 57.14% сайн, 36 буюу 23.38% дунд зэрэг, 5 буюу 3.25% муу гэсэн сэтгэл ханамжийн үнэлгээ өгсөн байна. Үр дүн:Амбулаторийн тусламж үйлчилгээ авсан хэрэглэгчээс сэтгэл ханамжийн үнэлгээ хангалттай 92.36%, Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ авсан хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ хангалттай 73.37% буюу дунджаар 82.85% үнэлэгдсэн байна.	
2.7.4	Эрсдэлийн менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг ЭМБ-уудын чанарын албатай хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалт зохион байгуулж идэвхжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэгт хяналтаар хамтран ажиллана.	-	Сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан ажилтны тоо	120	150	-Шинээр гарсан ЭМС-ын А/112 тушаалыг танилцуулах, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийг бууруулах чиглэлээр Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг Дархан-Уул аймгийн хэмжээнд нийт 21 эрүүл мэндийн байгууллагыг http://eburtgel.hdc.gov.mn цахим прагмод бүртгэл үүсгэж баталгаажуулсан. Цахим программд нийт 105 тохиолдол, 67 эрсдэл бүртгэгдэн шийдвэрлэсэн байна. ЭМХТ-ийн 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн №197 албан бичгийн дагуу ЭМГ-ын улиралын хяналт үнэлгээгээр ЭМБ-дад хяналт хийн, Эрүүл мэндийн байгууллагуудад цахим программд тохиолдол бүртгэх үйл ажиллагааг идэвхижүүлэх талаар зөвлөмж өгсөн. Эрүүл мэндийн байгууллагын 150 эмч мэргэжилтнийг чадвахжуулах “Нэн тэргүүнд ХАБЭА” сэдэвт сургалт	100

						зохион байгуулахад оролцож ажлын байрны эрсдэлийн менежмент ,эрсдэлээс сэргийлэх сэдвээр илтгэл тавьсан.	
2.7.5	“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартын үнэлгээ хийж үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	1,200.0	Үнэлгээний тайлан, зөвлөмж	-	Үнэлгээ хийж,тайлан, зөвлөмж өгсөн байна.	“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартад үнэлгээ хийж 7 төрлийн зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 74%-тай байна. Зөвлөмжийн дагуу Нэгдсэн эмнэлгийн Лабораторийн үйлчлүүлэгчээс шинжилгээ авах хэсгийг шинэчлэн засварлаж иргэдэд үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг сайжруулсан. Мөн Аминхолбоо өрхийн эмнэлэг гаднах хаягаа шинэчлэн кирил, монгол бичгээр байршуулсан байна.	70
Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр 7 зорилт 37 арга хэмжээний хэрэгжилт 96.4%							
3. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:							
Зорилт 3.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн сургалт хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах							
3.1.1	Эрүүл мэндийн газрын Хүнийн нөөцийн бодлого зохицуулалт хийж ажиллана. (Төрийн албаны тухай хуулийн 42, 43 дугаар зүйл, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйл)	-	Тушаал шийдвэр	67	Тухай бүр	Нийт 76 бүтэц орон тоотойгоор 5 хэлтэс, 1 НЭМТөвтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/148 дугаар “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай ажлын хэсэг байгуулах тухай тушаал” болон Эрүүл мэндийн яаманд Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэл, төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын жишиг тодорхойлолт шинэчлэгдэж байгаатай холбогдуулан сул орон тоог түр хугацаагаар зогсоосон. ЭМГ-т одоогоор ТЗ-ын 24 албан хаагч, ТҮ-18 албан хаагч, ТҮЭМ-31 ТҮМ-3 албан хаагч (түр чөлөөлсөн-10)бүртгэлтэй байна. Мөн эрүүл мэндийн газрын сонгон шалгаруулалтаар ТҮ-гийн албан тушаал дээр 2 албан хаагчийг ажилд сонгон шалгаруулж хүний нөөцийн бүрдүүлэлт хийж ажилласан. Мөн 8,9,10-р	100

						сард 5 хүн чөлөөлөгдсөн ба 3 албан тушаалтан 40%-иар хавсран ажиллаж байна.	
3.1.2	Эрүүл мэндийн ажилтны цахим бүртгэлийн програмын хэрэгжилтийг ханган ажиллана. (Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-д нийцүүлэн төрийн албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлж, баяжилтыг тухай бүр хийж хэвших)	-	цахим бүртгэл	- Хамраг дсан хүний тоо-76	Хамрагдах хүний тоо-76	Дархан-Уул аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр хувийн хэвшлийн болон боловсролын байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын нийт 114 ажилтнуудад / http://www.hdc.gov.mn /эрүүл мэндийн ажилтны цахим бүртгэлийн программын ашиглалтын талаар удирдлага арга зүйгээр хангаж, эрүүл мэндийн эмч мэргэжилтэн өмнө бүртгэлтэй байсныг салбарын хэмжээнд бүх ажилчдыг програмд бүртгэн нэгдсэн дата санг үүсгэсэн. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлд хяналт тавьж ажилласан. 2025 оны мэргэжлийн сургалтын багц цагийн биелэлт 85%-тай. 87 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч цахим бүртгэл ашиглалтын талаар болон багц цагаа сунгуулах, мэргэжлийн зэргийн шалгалтад орох, кредит цагийн биелэлтээ хангах мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системд Төрийн албаны 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын дагуу 67 ажилтны төрийн албан хаагчийн анкет, хувийн хавтас бүрдүүлэлтийг шинэчилж, төрийн албаны цахим программ ХНУМТ-д 77 ажилтны материалыг нэг бүрчлэн шивж шинэ ажилчдын мэдээллийг тухай бүрт шинэчилсэн.	100
3.1.3	Үндсэн болон төрөлжсөн чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх болон төрөлжсөн мэргэшил эзэмших, эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг чадавхижуулахад дэмжлэг үзүүлнэ.	2000.0	бэлтгэсэн мэргэжил тэний тоо	12 эмч мэргэжилтэн	15 эмч мэргэжилтэн	Улсын төсвийн санхүүжилтээр үндсэн мэргэжлээр 8, төрөлжсөн мэргэжлээр 7, мэргэжил дээшлүүлэхээр 6 их эмч суралцаж байна. Сувилагч тусгай мэргэжилтэн төрөлжсөн мэргэжлээр 5, мэргэжил дээшлүүлэхээр 3 Үр дүн: 21 их эмч, 8 сувилагч хамрагдсан.	100

3.1.4.	Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнийг дээд шатлалын эмнэлэгт дадлагажуулан сургах, орон нутагтаа мэргэжлийн баг урьж ажлын байранд дадлагажуулан чадавхижуулахад мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.	500.0	Хамрагдсан мэргэжилтний тоо	Хамрагдсан хүний тоо-30	Хамрагдах хүний тоо-35	УНТЭ-ийн Монгол Улсын төрийн соёрхолт, АУ-ны доктор Д.Баян-Өндөр эмчээр ахлуулсан баг НЭ-ийн бөөрний дээд замын чулуужих өвчний ажлын байрны онол, дадлагын сургалтад 7, Монголын сувилагчдын нийгэмлэгээс Эрдэнэт хотод зохион байгуулсан “Эмнэлгийн халдварын хяналт ба сэргийлэлт” сэдэвт сургалтад 2, Сувилахуйн алба “Монгол-Японы эмнэлэг”-т 2 ажилтан туршлага судалсан. ЭМС-ын тушаалаар батлагдсан төвлөрлийг сааруулах “ҮНДЭСНИЙ БАГ” Нэгдсэн эмнэлэгт ажилласан. Үүнд: 1. ХСҮТөвийн баг “Хавдрын тусламж үйлчилгээний орчин үеийн чиг хандлага” сэдвээр сургалт зохион байгуулж 51 эмч, мэргэжилтэн. 2. ЭХЭМҮТ-ийн “Хүүхэд,нярайн” Үндэсний баг ЭМБ-уудын удирдлага болон хүүхэд, нярайн эмч нартай уулзалт хийж Дархан –Уул аймгийн хүүхэд, нярайн тусламж үйлчилгээний одоогийн байдал болон цаашдын үйл ажиллагааны хэлэлцүүлгийг зохион байгуулж 16 мэргэжилтэн оролцсон. ХАЯТ тасгийн Т. Бадамцэцэг эрхлэгчтэй баг Шарын гол сумын эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэнгүүдэд “Амилуулах суурь тусламж”-ийн онол, дадлагын сургалт зохион байгуулсан. Хамрагдсан 22. ХСҮТ-д хавдрын тусламж үйлчилгээгээр 4 ажилтан богино хугацаны сургалтанд хамрагдсан. Хүний нөөцийн сургалт хөгжлийн хөтөлбөрийн дагуу: Ажлын байрны 29 удаагийн сургалтаар 1048 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан албан хаагч нар сургалтад хамрагдсан. -МУ-ын Хүний эрхийн үндэсний комиссын Дархан – Уул аймаг дах салбараас "Хүний хувийн мэдээлэл хамгаалахад анхаарах асуудлууд" сэдэвт сургалтыг 45 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан хамрагдсан байна. Дүрс оношилгооны эмч нарт АШУҮИС, АУС-ийн Радиологийн тэнхим, МоЯЭ-ийн Радиологийн төв,	100
--------	---	-------	-----------------------------	-------------------------	------------------------	--	-----

						Монголын Радиологийн Нийгэмлэг, Австралийн Radiology Across Borders /RAB/ ОУ-ын байгууллагын "VITAL" төслийн Хэт авиан оношилгооны чадавхижуулах эмнэлзүйн гардан сургалтыг аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, Дүрс оношилгооны тасгийхан хамтран 3 хоног зохион байгуулсан. Тус өдрүүдэд хөх, үе, судасны хэт авиан онолын болон гардан сургалтанд дүрс оношилгооны эмч нар болон гэмтлийн эмч нар хамрагаж сертификат олгосон. -“Улаан бурхан өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээ” сэдэвт сургалт. 5 удаа Хамрагдсан эмч, сувилагч 485. -Ажлын байрны, дагалдуулах, “Эмнэлгийн асрагчийн мэргэжлийн баримжаа олгох сургалт”-д 53 ажилтан хамрагдан, үнэлгээний дундаж 72%.	
3.1.5.	Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлийн чиглэлээр гадаадад богино болон урт хугацааны сургалтад хамруулж чадавхижуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.	10.000.0	- Сургалта д хамрагдс ан мэргэжил тний тоо	- Гадаад ад 5 эмч мэргэжи лтэн	Гадаадад 6 эмч мэргэжил тэн	Монгол улсын төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” төвийн бүсийн зөвөлгөөн Дархан-Уул аймагт зохион байгуулагдаж тус зөвлөгөөнд ЭМГ-аас “Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлэг”-т төрийн захиргааны 4 мэргэжилтэн, Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлэг-т ЭМГ-ын ёс зүйн дэд хорооны 3 мэргэжилтэн, Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих, төрийн албан дахь удирдах түвшний жендер-сургалтад удирдах түвшний 3 эмэгтэй албан хаагчийг хамруулсан байна. ӨМӨЗО-ы Хөх хотын “Ардын 1-р эмнэлэг”, “Ардын 2-р эмнэлэг”-т НЭ-ийн 6 ажилтан “Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, хэрэгжилт, гэмтлийн хагалгааны дараах асаргаа сувилгаа, сэргээн засах” чиглэлээр туршлага судалсан. БНХАУ-ын Өвөрмонголын Олон Улсын Монгол эмнэлгийн хороонд “Уламжлалт анагаах ухаан, сэргээн засал” чиглэлээр 5 хоногийн сургалтад төрийн санхүүжилтээр хамрагдсан.	100

					Амаржих тасгийн эрхлэгч БНСУ-ын Жеонжу хотын Софиа эмнэлэгт "Шээс задгайрал, эмэгтэйчүүдийн пластит мэс заслын шинэ техник сурах богино хугацааны сургалтанд хамрагдсан. 2025.09 сард Испани улсын Мадрид хотод болох "ESC congress 2025 Madrid" олон улсын хуралд дотрын тасгийн эрхлэгч Г.Бадамлянхуа, поликлиник-1 тасгийн зүрх судасны их эмч Ш.Оюунсайхан нар хамрагдсан. 2025.09 сард БНСУ-д зохион байгуулагдах "15th international congress of diabetes and metabolism /ICDM 2025/"-д поликлиник-1 тасгийн Б.Цэцэгсүрэн, М.Хандмаа, Р.Гүнжлхам нар илтгэл тавьсан. 2025.09 сард Казахстан улсад "Koche-2025" ОУ-н семинарт эмнэлзүйн-эмгэг судлаллын лабораторийн тасгийн эрхлэгч М.Мөнхзул оролцсон. ЭМЯ-аас зохион байгуулсан 21 аймгийн хүний нөөцийн мэргэжилтнүүдийн чадавхижуулах ажлын хүрээнд БНХАУ-н Хөх хотын эмнэлэгт 5 өдрийн туршлага судалсан. Гадаадын 5 улсад , 7 чиглэлээр сургалтанд 10 эмч мэргэжилтэн, 6 сувилагч хамрагдсан.	
3.1.6.	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын оролцоог нэмэгдүүлэх татан оролцуулна.	300.0	Сургалта д хамрагдс ан мэргэжил тний тоо	485 эмч, мэргэжи лтэн	Эмнэлгийн мэргэжилтэн нэгээс доошгүй удаа ёс зүйн сургалтад хамрагдсан байх 450 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо нь "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага, нөлөөлж буй хүчин зүйл манлайлал, байгууллага хамт олны соёл" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн Дэлхий эмч нарын өдрийг угтаж "Эмч бидний харилцаа" сэдэвт ёс зүйн сургалтыг ЭТҮХ, НЭ-ын ёс зүйн салбар хороотой хамтарч сургалтад ЭМГ, НЭ ӨСЭМТ, ХХЭМБ-уудын нийт 120 эмчийг хамруулсан байна. Тэгш анар ХХК-тай хамтран Олон улсын эм зүйчийн өдрийг угтан ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сэдвээр мэдээлэл өгч 85 эмч, эмзүйч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. "Ёс зүйн үндэс, Мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн үүрэг хариуцлага, ёс зүйн кодекс, Ёс зүйн зөрчил" зэрэг сэтгэлзүйн сургалтыг Нэгдсэн	100

						эмнэлгийн ёс зүйн хэсгийн хорооны дарга Б.Төрмөнх эмч хийв. Сургалтад нийт 75 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан албан хаагч хамрагдав. .Ёс зүйн чиглэлээр 5 удаагийн дотоодын сургалтыг зохион байгуулж 196 эмнэлгийн ажилтан, албан хаагч хамрагдсан. Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Монгол Улсын Их хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Ёс зүйн дэгийн байнгын хороо, Монгол Улсын Ёс зүйн хороо, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлүүд хамтран зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” Төвийн бүсийн 2 өдрийн зөвлөгөөний үеэр ЭМГ-ын мэргэжилтнүүдийн хамт иргэдэд мэдээлэл зөвлөмж өгч, сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажилласан.	
3.1.7	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллана.(төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг хос бичгээр хөтлөх, төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэх)	1.000.0	сургалтад хамрагдсан албан хаагч	30	50	ЭМГГазар нь 2025 оноос албан тоот, тушаал шийдвэр, дүрэм, MNS 6395:2022, MNS : 5283:2022 стандарт дагуу хос бичгээр хөтлөж хэвшүүлж ажиллаж байна. Явсан бичиг-239, А тушаал-49, Б-26 албан бичгийг хос бичгээр хөтөлсөн. НЭ-ээс “Монгол бичиг-Бидний өв сан” сарын аяныг зохион байгуулж 61 ажилтан хамрагдсан.. Улирал бүр Монгол бичгээр хэвлэгддэг “Уламжлал” сэтгүүлийг захиргааны хэрэгцээнд захиалж, албан тасаг, нэгжийн хаягуудыг монгол бичгээр шинэчилсэн. ЭМГ-ын албан хаагч нар компьютерийн гарт монгол бичгээр бичиг фонд суулгаж суралцаж байна. Аминхолбоо өрхийн эмнэлэг нь гадна хаягаа кирилл монгол бичгээр шинэчлэсэн.	100
3.1.8	“Шинэ сувилагч”-ийг ажлын байранд дадлагажуулан сургах хөтөлбөрийг	500.0	Хөтөлбөрт хамрагдсан	7	10-15	Шинэ сувилагчийг ажлын байранд дадлагажуулан сургах хөтөлбөр “Clinic Leader”-ийг хэрэгжүүлэн 7 сувилагчийг 3 удаагийн сургалтанд хамруулсан. Эрүүл мэндийн яам болон Японы олон улсын хамтын	100

	хэрэгжүүлэн ажиллана. /100 хоногийн сургалтын хөтөлбөр боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулах/		сувилагч мэргэжил тний тоо			ажиллагааны Жайка байгууллага хамтран “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн хүрээнд “Шинэ сувилагчийн сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулсан ба хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хэсгийг ЭМГ-ын даргын А/124 дүгээр тушаалаар томилж, тус хөтөлбөр төлөвлөгөөний дагуу нийт 48 шинэ сувилагчид “Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, “Сувилагчийн хөгжил, манлайлал” сэдвээр сургалт зохион байгуулсан. Нэгдсэн эмнэлэгт шинээр ажилд орсон сувилагч нарт гараас гарт зарчмаар зөвлөмжийн хамт хүлээлгэн өгч туршилтын 3 сарын хугацаанд үнэлгээний хуудсаар дүгнэж ажлын байран дээр сургаж байна.	
Зорилт 3.2. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана							
3.2.1	Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдад шагнал, зэрэг дэв, урамшуулал олгоход дэмжиж ажиллана.	-	шагнал урамшуул алд хамрагдс ан хүний тоо	-80	-120	Засаг даргын нэрэмжит “Сувилахуйн гэгээн дагина” Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан “Энэрэхүйн үйлстэн” үйл ажиллагаанд 1,471,000 төгрөгийн мөнгөн шагнал, бусад зардлыг шийдвэрлэсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын эмч эмнэлгийн мэргэжилтэнг аймаг, яам, төрийн шагналд тодорхойлох, холбогдох байгууллагуудад материалыг хүргүүлж нийт 164 шагналыг Шинэ жил, Цагаан сар, Дэлхийн эмч нарын эрхийг хамгаалах өдөр, Олон улсын сувилагч нарын өдөр, Эмнэлгийн ажилчдын баярын өдрөөр тус тус гардуулсан байна. ЭМС-ын Шилдэг 7 номинацийг хэлэлцүүлж, урамшуулсан байна.	100
3.2.2	Эмч, ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг	500.0	-Үзлэгт хамрагдс ан ажилтны тоо	-520 эмнэлги йн ажилта н	-550 Ажилтан Эрүүлжил т 68%	Ажилчдын урьдчилан сэргийлэх хуваарь гарган шинжилгээнд хамруулсан. 410 ажилтан хамрагдсан ба MRSA халдвар тээгч 5 ажилтныг эмчилгээнд хамруулж байна. Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эмнэлгийн ажилчдын дунд нэмэлт	90

	зохион байгуулна.		- Эрүүлжил тийн хувь	Эрүүлж илт 64%		дархлаажуулалтыг нийт 3 удаагийн давтамжаар 270 ажилтанг дархлаажуулсан. Эрчүүдийн эрүүл мэндийн өдрийг угтан ЭМГ, НЭ, СЭМТ, ӨЭМТ-ийн 40-өөс дээш насны 37 эрчүүдийг үзлэгт хамруулсан. Илэрсэн өвчлөлийн эрүүлжилт 61%-тай байна. Мөн сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг угтан эрүүл мэндийн газрын эмч эмнэлгийн албан хаагчдыг сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цээжний рентген аппаратны оношилгоонд хамруулсан. Нийт 33 ажилтан албан хаагч хамрагдсан. Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжин хүн бүрт 150 ширхэгтэй витамин Ц /1000мг/ тарааж, 590 албан хаагч хамрагдсан. Нийт ажилтнуудын бие бялдрын үнэлгээнд хамруулахад 26 алба тасаг нэгж, нийт-388 ажилтан хамрагдсан .	
3.2.3	Эрүүл мэндийн ажилчдын ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангахад дэмжиж ажиллана.	2,500.0	- Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийн хангалтийн тоо - Зарцуулсан төсөв	-110 сая	Гүйцэтгэл ээр	Эрүүл мэндийн газрын нийт ажилтан албан хаагчдийг ажлын гадуур хувцасаар жигдрүүлэх ажлын хүрээнд 45 ширхэг малгай, бомбер, хантааз захиалж 9.652.500 төгрөг зарцуулсан. Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн ажилчдын ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлэхээр ЭМГ-ын 1-р давхрын буюу Амбулатори-2 тасгийн коридор, Сүрьеэгийн диспансерын дотор засвар болон сүрьеэгийн диспансерын агааржуулалтын системийг сэргээн засахад 29.8 сая, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлд 6,5 сая зарцуулсан байна. Уламжлалтын тасгийн 8 плат, Хагалгааны нэгдсэн тасагт засвар хийсэн байна.	100
Хүний нөөцийг чадавхижуулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр: 2 зорилт 11 арга хэмжээний хэрэгжилт 99%							
4. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:							
Зорилт 4.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжүүлэх тогтолцоог хэрэгжүүлэх							

4.1.1.	Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлд суурилсан цалин, урамшууллыг олгоно.	500,00 0.0	гүйцэтгэл д суурилса н санхүүжи лт	100%	Гүйцэтгэл ээр	3 дугаар улирлын байдлаар Эрүүл мэндийн газар 65 ажилтанд 1,531.3 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал олгосон, үүнээс 85.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, Нэгдсэн эмнэлэг 578 ажилтанд 12,425.9 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, үүнээс 471.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, Хонгор СЭМТ 25 ажилтанд 673.6 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, үүнээс 33.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, Орхон СЭМТ 21 ажилтанд 692.1 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, үүнээс 58.8 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, Шарын гол СЭМТ 44 ажилтанд 1,299.7 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, үүнээс 32.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон. Өрхүүд Аминхолбоо 26, ГОС ХОТ 51, Гэрэлтэй 22, МЭДС ТОБ 29, Түвшинхолбоо 25 нийт 153 ажилтанд 2,818.2 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, үүнээс 220.9 сая төгрөгийг үр дүнгийн урамшуулал олгосон. Салбарын хэмжээнд нийт 886 ажилтанд 19,440.8 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал олгосон, Үүнээс 1, 2-р улирлын үр дүнгийн урамшуулалд 901.7 сая төгрөг олгосон байна.	100
4.1.2.	Төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангана.	-	Шилэн дансны мэдээлэл	Шилэн дансны мэдээлэл 99%	Шилэн дансны мэдээлэл 99%	Шилэн данс хөтлөлт 2025 оны 3 улирлын байдлаар 780 мэдээлэл 774 мэдээллийг хугацаандаа мэдээллэсэн, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн. Байршуулах ёстой мэдээллийг бүрэн байршуулсан боловч 6 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан тул салбарын хэмжээнд гүйцэтгэл 99,2% байна.	100%
4.1.3.	Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид бичгээр	-	Албан бичгийн тоо	5	Тухай бүр	Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Эрүүл мэндийн сайдад аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийлгэх хүсэлтийг улирал бүр 1 удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр гаргасан. Үүнд: ЭМГ 4 удаа гаргаж 3 удаа шийдвэрлэгдсэн, гүйцэтгэлийн байгууллагууд буюу Нэгдсэн эмнэлэг, СЭМТ-үүдийн төсөвт зохицуулалт хийлгэх хүсэлтийг 3 удаа гаргаж, шийдвэрлүүлж ажилласан..	85

	хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.						
4.1.4.	Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож тооцсон талаарх тайлангаа тухай бүрт нь Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.	-	Өр авлагагүй байх	Өр авлагагүй ажилла сан	Өр авлагагүй ажиллах	2025 онд ЭМД-ын гүйцэтгэлийн санхүүжилт дутуу орж ирсэнээс Нэгдсэн эмнэлэг 3,749.6, Хонгор СЭМТ 101.1 сая, Шарын гол СЭМТ 79.9 сая, Орхон СЭМТ 125.3 сая, нийт 4,055.9 сая төгрөгийн өртэй гарсан ба 2,818.1 сая төгрөгийн ЭМД-ын санхүүжилтийн авлагатай гарсан. 2025 оны 1-р сард 2024 оны ЭМД-ын санхүүжилтийн авлага 2,818.1 сая орж ирсэн ч тухайн сарын буюу 2025 оны 1-р сарын санхүүжилт орж ирээгүй ба сарын хоцрогдолтой явсаар 2025 оны 9-р сар хүрч байна. 2025 оны 9-р сарын байдлаар ЭМГ нийт төсвөөс хэтэрсэн өр байхгүй ба төсвийн тодотголоор төсөв хасагдсан, төсвийн хуваарийн хойш тавигдсан, гэрээ баталгаажаагүй, санхүүжилт орж ирээгүй зэрэг асуудлаас шалтгаалж 236.4 сая төгрөгийн өртэй байна. Үүнээс 9-р сарын тэтгэмжийн санхүүжилт орж ирээгүйгээс 214.8 сая төгрөгийн өр үүссэн нь нийт өрийн 90.8 хувийг эзлэж байна. Тэтгэмжийн санхүүжилт орж ирэх эсэх нь улсын төсөвтэй холбоотой. Тэтгэмжээс бусад 21.6 сая төгрөгийн өрийн 19.2 сая төгрөгийн өр нь 10-р сард бүрэн барагдах ба үлдсэн 2.4 сая төгрөгийн тухайн эдийн засгийн ангиллын хувьд төсөв дутсанаас үүссэн өр бөгөөд төсөвтөө зохицуулалт хийж шийдэх боломжтой учраас ЭМЯ-нд зохицуулалтын санал хүргүүлсэн. Иймд ЭМГ-ын хувьд үүссэн өр нь түр хугацаанд үүссэн өр бөгөөд 10, 11 сард бүрэн барагдуулж өргүй болно. Нэгдсэн эмнэлэг 9-р сарын байдлаар нийт авлага 3,022.0 сая төгрөг байна. Үүнээс ЭМДС-аас 3,011.8	70.0%

						сая төгрөгийн авлагатай байна. 2025.09.30-ны дансны үлдэгдэл 366.7 сая байна. Нийт өр 4,289.3 сая төгрөг байна. Үүнээс цалин, НДШ 2,144.7 сая, 1,985.4 сая төгрөг буюу нийт өрийн 96.3 хувийг эзлэж байна. Авлага болон дансны үлдэгдэл нийт 3,388.7 сая төгрөг байна. Үүнээс өрийг хасвал (3,388.7 сая – 4,289.3 сая) 900.6 сая төгрөгийн алдагдалтай байна. 2025 оны 9-р сарын байдлаар СЭМТ-үүдийн хувьд ЭМД-ын санхүүжилт хугацаандаа орж ирэхгүй авлага үүсч байгаатай холбоотой өр үүсч байна. ЭМД-ын санхүүжилтын авлага орж ирсэн тохиолдолд авлагаар өр төлбөрөө барагдуулах бүрэн боломжтой ажиллаж байна. Хонгор СЭМТ ЭМДС-аас 60.7 сая төгрөгийн авлагатай. Дансны үлдэгдэл 190.9 сая төгрөг байна. 155.7 сая төгрөгийн өртэй байна. Хонгор СЭМТ-ийн нягтлан бодогч солигдож гарын үсэг баталгаажаагүйгээс 9-р сард гүйлгээ хийж чадаагүйгээс өр хуримтлагдаж өндөр болсон. Авлага болон дансны үлдэгдлийн нийлбэрээс өрийг хасвал 95.9 сая төгрөгийн эерэг үр дүнтэй байна. Орхон СЭМТ ЭМДС-аас 92.7 сая төгрөгийн авлагатай. 20.5 сая төгрөгийн өртэй байна. Шарын гол СЭМТ ЭМДС-аас 52.3 сая төгрөгийн авлагатай. 34.8 сая төгрөгийн өртэй байна. ӨЭМТ-үүдийн хувьд өргүй ажиллаж байна.	
Эрүүл мэндийн санхүүжилтийн чиглэлээр: 1 зорилт 4 арга хэмжээний хэрэгжилт 88.75%-тай байна.							
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:							

Зорилт 5.1. Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллах							
5.1.1	Зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт бусад дэмжлэгийг Аймгийн Засаг даргын нөөц сан, орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлэх талаар санаачлагатай ажиллана.	100,00 0.0	Тоног төхөөрөм ж	612.800. 000	Гүйцэтгэл ээр	Аймгийн ОНХО-ын 2024-2025 оны шилжих хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлэгт үений дурангийн мэс заслын тоног төхөөрөмж 518.0 сая төгрөгөөр Ай Эм Эс Инженеринг ХХК нийлүүлсэн, Нэгдсэн эмнэлгийн гадна авто зогсоолыг өргөтгөхөд 418.5 сая төгрөгөөр Билигт Инженеринг ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, автомашин худалдан авахад 326.2 сая төгрөг батлагдаж аймгийн ХАА-ны газар тендер зарласан боловч оролцогч ирээгүй байна. 2025 онд Нэгдсэн эмнэлгийн уламжлалтын тасгийн засвар хийхэд аймгийн төсвөөс 20.0 сая төгрөг батлагдаж засвар хийгдэж дууссан. Хонгор сумын засаг даргын нөөц сангаас 10.0 сая төгрөгийн ухаалаг дэлгэц, суурин компьютер өгсөн. Орхон сумын ОНХО-ын хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн төвийн барилгын гадна фасат, дээврийг засаж шинэчлэх ажлыг 287.9 сая төгрөгөөр Онцот Баянхайрхан ХХК гүйцэтгэж дууссан.	100
Эрүүл мэндийн технологийн чиглэлээр: 1 зорилт 1 арга хэмжээний хэрэгжилт 100%-тай байна.							
6.ЭМЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:							
Зорилт 6.1 “Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, цахим бүртгэл, хяналтыг сайжруулж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх” зорилтын хүрээнд							
6.1.1	Эмийн цахим жор бичих эмч нарт эрх олгох, хаах үйл ажиллагааг зохион байгуулж, жор бичилтэд хяналт тавьж ажиллана.	100.0	Цахим жор бичиж буй эмч нарын тоо Жор бичилтэд хяналт тавьсан байдал	150 эмч	150 эмч	Өрх сумын эрүүл мэндийн төвд цахим жор бичих их эмч нарт тухай бүрд цахим жор бичих эрх олгох, цуцлах ажлыг тусламж үйлчилгээг алдагдуулалгүй тогтмол хийж байна. 2025 онд Эрүүл мндийн газраас нийт 45 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд цахим жор бичих эрх нээж, ажлаас гарсан болон жирэмсний амралт авч хаасан-21 байна. Аминхолбоо ӨЭМТ-7, ГОСХОТ ӨЭМТ-17, Гэрэлтэй ӨЭМТ-4, Шарынгол СЭМТ-11, МЭДСТОБ ӨЭМТ-10, Орхон СЭМТ-6, Түвшинхолбоо ӨЭМТ-6, Хонгор	100

						СЭМТ-6, Нэгдсэн эмнэлэг 149 их эмч цахим жор бичих эрхтэй буюу нийт 216 их эмч цахимаар ЭМД болон энгийн эмийн цахим жор бичиж байна.	
6.1.2	Эмийн зохистой хэрэглээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээ хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллана.	-	Хамрагдсан эмч мэргэжилтэн, үйлчлүүлэгчийн тоо	Эмнэлгийн ажилтан 400 Үйлчлүүлэгч 1200	120 эмч эмнэлгийн мэргэжилтэн, 2000 иргэн	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас ирсэн 2025 оны 1 сарын 14-ний өдрийн 01/60 хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд: -Эм хангамжийн байгууллагын ажилчдын хууль эрх зүйн мэдлэг,харилцаа хандлагыг сайжруулах нь сургалтыг Эмийн жор бичилтийн стандарт, Цахимаар жор олгох бичих түр заавар,Эм,эмнэлгийн хэрэгслийн шинэчилсэн найруулга сэдвээр зохион байгуулж 88 эм хангамжийн ажилчид, 78 эмч мэргэжилтэнг хамруулсан. Эмийн хэрэглээ ба гаж нөлөө сэдэвт сургалтыг ЭЭХХЗГ салбарын хяналтын байцаагч, Санто эмийн компанитай хамтран 28 эм зүйч, жор баригч нар мэдээлэл өгсөн. Эмзүй албаны зохион байгуулалт, менежмент сургалтад хувийн хэвшлийн эмийн сангийн 9 эм зүйчийг цахимаар АШУҮИС-ын Эмзүйн сургуульд суралцах боломж бүрдүүлсэн. Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Тэгш анар ХХК-тай хамтран Олон улсын эмч нарын өдрийг угтан ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Эмч бидний харилцаа” Зах зээлд шинээр нэвтэрч буй эмийн мэдээлэл,олон улсын судалгаа шинжилгээ сэдвээр мэдээлэл өгч ажилласан.Нийт 120 эмч хамрагдсан. Хүүхдийн чих хамар хоолойн эмгэгийн үеийн яаралтай тусламж үйлчилгээ, тулгамдсан асуудал, оношилгоо эмчилгээ” сэдэвт эмнэл зүйн кредиттэй	100

					сургалтыг ЭХЭМҮТ-тэй хамтран 120 эмч, эм зүйч нарт зохион байгууллаа. Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016 стандартын дагуу жороор хангах, жор бичилтийг төлөвшүүлэх, сайжруулах тогтмол хяналт тавьж, аргазүйгээр ханган ажилласан. 2025 он энгийн эмийн цахим жор бичилт 13,487, ЭМД-р хөнгөлттэй олгох эмийн цахим жор -119508 бичигдсэн байна. ЭЭХХЗГ-с 2025 оны 09 дүгээр сарын 11-нд ирсэн 01/1611 албан тоот, Эмийн зохистой хэрэглээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд цахим хуудас болон DBS телевизээр дамжуулан иргэдэд зориулсан 9 төрлийн нэвтрүүлэг, рийл, контент, шторк бэлдэн олон нийтэд эмийг зохистой хэрэглэх мэдээлэл хүргэн ажилласан. Хандалт 5000 мянга давсан, Нэгдсэн эмнэлэг болон нийтийн үйлчилгээний эмийн сантай хамтран Амбулаториор үйлчлүүлж буй иргэдэд 2025.09.25-нд эмийн зохистой хэрэглээ өдөрлөг зохион байгуулсан. Нийт 200 гаруй хүнд мэдээлэл хүргэн ажилласан.	
--	--	--	--	--	--	--

6.1.3	ЭМБ-уудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдал чанар аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж ажиллана	200.0	Нөөц бүрдүүлэлт	1-2 сарын нөөцтэй	1-2 сарын нөөцтэй	Хамтарсан багийн хяналт үнэлгээгээр 3 сум, 5 өрх нэгдсэн эмнэлгээр хяналт үнэлгээг Мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн жор бичилт,жорын зарцуулалт, Эмийн нөөц,чанар аюулгүй байдал, хадгалалт гэсэн үзүүлэлтээр хийсэн. ЭМС-ын А/388 тушаал амин чухал эмийн 2 сарын нөөцтэй. МУ-ын Үндэсний аюулгүй байдлыг зөвлөлөөс 2025.06.10-14 өдрүүдэд зохион байгуулсан “СӨРГӨӨ -2025” команд штабын дадлага сургуулалтад оролцож төвийн бүсийн хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгслийн нөөц, авто машин, техник хэрэгслийн нөөц судалгааг гаргаж , бэлтгэл бэлэн байдал, холбогдох албан тоот төлөвлөлт, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилсэн. ЭМБ-уудын эм эмнэлгийн хэрэгслийн нөөц судалгааг 2025. 06 сарын 10-ны байдлаар авч шинэчилсэн нөөц 1-3 сар байна. ЭМС-ын 2024 оны А/11 тоот тушаалаар батлагдсан журамд заасан Жирэмслэлтээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, худалдан авах, зарцуулах, тайлагнах бүртгэл, тайлагналтын чанарыг сайжруулах, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдлэг олгох арга зүйн сургалт зохион байгуулж 8 эмзүйч хамрагдсан.	100
6.1.4	Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулга хийсэн байдалд хяналт тавьж ажиллана.	200.0	Засвар, тохируулга хийсэн тоо	25 нэр төрлийн 50 багаж тоног төхөөрөмж	Шаардлагатай тоног төхөөрөмжийн тоогоор	Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээнд 85 ширхэг багаж тоног төхөөрөмжийг стандарт хэмжил зүйн газраар 1.1 сая төгрөгөөр, 50 ширхэг термометрийг 1 сая төгрөгөөр Улаанбаатар хотноо мэргэжлийн байгууллагаар баталгаажуулалт хийж ашиглаж байна . Эм эмнэлгийн тоног төхөөрөмжийн хуульд өөрчлөлт орж мэргэшсэн явуулын баг орон нутагт ажиллах болсонтой холбоотойгоор шаардлагатай тохиолдолд	100

						Нэгдсэн эмнэлгийн багаж тоног төхөөрөмж гэмтэл гарсан 2 тохиолдолд ЭЭХЗГ -т хүсэлт илгээж 2 удаа инженер техникийн багийг урьж ажиллуулан гэмтлийг зассан.	
6.1.5	Эм зүйн салбарт мөрддөг хууль, стандартын хэрэгжилтийг хангуулахад мэргэжил арга зүй, дэмжлэгт удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.	500.0	Хяналт үнэлгээ хийсэн байгуулл агын тоо	7 ЭХНБ, 46 эмийн сан	40 эмийн сан	ЭМД хэлтсээс ирсэн 2025 оны 02 сарын 17-ны 13/48 зөрчил шийдвэрлүүлэх тухай албан тоотын дагуу ЭХНБ Дархан ХХК-ний Дархан Уул 1 эмийн сангийн хүний нөөцийн зөрчлийг арилгуулан холбогдох материалыг албан тоотоор хүргүүлсэн. Эм хангамжийн салбарын 2025 оны хүний нөөцийн судалгааг шинэчилсэн.Дархан-Уул аймгийн хэмжээнд нийт 72 эмийн сан, 7 эм ханган нийлүүлэх үйл ажиллагаа явуулж байна. 1-р зэрэглэл 6, мансууруулах сэтгэцээр үйлчилдэг 4, ЭМД хөнгөлттэй эмээр үйлчилдэг 42 эмийн санд тогтмол хяналт тавьж зөвлөмж мэдээллээр хангаж байна. Хүний нөөцийн мэргэжилтэнтэй хамтран Эрүүл мэндийн сайдаас 1313.mn сайтын үйл ажиллагааг тогтворжуулж,бодлого тодорхойлогчдыг чанартай, шуурхай тоон мэдээллээр хангах тухай албан үүргийн дагуу бүх эмийн сангууд одоо ажиллаж байгаа хүний нөөцийн мэдээллийг "Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан" hr.hdc.gov.mn программ дахь нийт эрүүл мэндийн ажилтны мэдээллийн бүртгэлийг хянан, ажлын туршлагыг баталгаажуулан 1313.mn сайтад байршсан нэгтгэлтэй тулгалт хийсэн. Бүртгэлгүй эмийн сангуудад бүртгэл үүсгэх заавар хүргүүлсэн. ЭМЯ-ны 2025.9.17-ны 2/4465 албан тоот, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн зарим заалт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38, 30 дугаар тогтоолд заасан цахим мэдээллийн нэгдсэн санд эм, эмнэлгийн хэрэгслийн хамгийн бага хэмжих нэгж, түүний суурь үнэ, бөөний үнэ,	100

						жигжиглэнгийн үнийг тухай бүр байршуулах, үнийн ил тод байдлыг хангах, эмийн үнийг нийтэд ил болгох ажлын хүрээнд эмийн сангийн үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, чиглэл өгч ЭМТҮХ болон ХШҮМХ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласан.	
6.1.6	Мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн жор хэвлэж олгох, зарцуулалтад хяналт тавьж ажиллана	-	Хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангах Тайланг хугацаанд ирүүлсэн байгууллага	14 байгууллага	4 эмийн сан 3 ЭХНБ 7 эмнэлэг	Мансууруулах сэтгэц нөлөөт эмийн жор бичих, үйлчлэх, эмийн хэрэглээнд хяналт тавих журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 4 эмийн сан, 3 ЭХНБ, 7 эмнэлэгт Эмийн мэргэжилтэн ЭМГ даргын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт үзлэг хяналтыг 2 удаа хийж ЭМЯ болон эм эмнэлгийн хэрэгслийг зохицуулах газарт 2024 оны тайланг хүргүүлэн нэг эмчийн эм бичих эрхийг түртгэлзүүлэн хяналт ажил хийгдэж байна -Мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг ЭМС-ын 2019 оны 68 дугаар тушаалын дагуу индексжүүлэн Нэгдсэн, өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэвлэн өгөх ажлыг зохион байгуулж жороор ханган ажиллаж байна. ЭМБ-уудад сэтгэцэд нөлөөт эмийн жор 1970 жор түгээсэн байна.	100

Эмзүйн тусламж үйлчилгээний чиглэлээр 1 зорилт 6 арга хэмжээний хэрэгжилт 100% байна.

7. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Зорилт 7.1. Хувь хүн, байгууллага, эрүүл мэндийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах

7.1.1.	Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн аюулгүй байдлын 4 багц хууль (Нийтийн мэдээллийн ил тод	-	Сургалтад хамрагдсан	151	155	Цагдаагийн газартай хамтран “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагынхаа ажилтан, алба хаагч нарт “Замын хөдөлгөөний дүрэм”, “Зөрчлийн тухай хууль”-иар сургалт зохион байгуулсан. Сургалтад Эрүүл мэндийн газрын 56	100
--------	--	---	----------------------	-----	-----	---	-----

	байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль)-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана.		ажилтны тоо			албан хаагч хамрагдсан. Эх үрсийн баяраар хүүхдүүдэд яаралтай тусламжийн үзүүлэх сургалт зохион байгуулж 6 хүүхэд хамрагдсан. Дархан сумын ГХЗУСА33-ийн хуралд нэг удаа оролцож 2025 оны төлөвлөгөөнд тусгах саналыг хүргүүлж ажилласан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 34 ажилтанд мэдээлэл хүргэж ажилласан байна. Аймгийн нэгдсэн эмнэлэг нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах Кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр 2024 онд Интернетээр дамжин байгууллагын сүлжээрүү орж байгаа халдлагыг илрүүлэх, хамгаалах зорилгоор WatchGuard M270 төхөөрөмжийг шинээр суурьлуулсан. Тагнуулын хэлтэстэй хамтран “Төрийн болон албаны нууцын хамгаалалтын тухай” “Кибер аюулгүй байдлын тухай” хуулийн сургалтыг зохион байгуулж 52 албан хаагч хамрагдсан. Төвийн бүсийн аймгуудыг хамруулсан “Цахим орчинд өөрсдийгөө хамгаалъя” сэдэвт сургалтад ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн мэдээлэл технологийн 2 ажилтан оролцсон. Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор ЭМГ-ын сайт болон Shilen.gov.mn сайт дээр улирал бүр ил тод нээлттэй байдлын мэдээлэл оруулсан.	
7.1.2.	Эрүүл мэндийн байгууллагуудад ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллах	200.0	Зохион байгуулсан үйл ажиллагаа	10	10	Эрүүл мэндийн байгууллагуудын хэмжээнд ХАБЭА-н 2025 оны төлөвлөгөөг эрүүл мэндийн газрын даргаар батлуулан НЭ, СЭМТ, ӨЭМТ-үүдэд хүргүүлэн шаардлагатай мэдээлэл арга зүйгээр ханган ажиллаж байна. ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 3 удаа Эмнэлгийн тоног төхөөрөмжийн академи, ХАБЭА-н мэргэжлийн сургалтын төвтэй хамтран 96 ажилтан албан хаагчийг хамруулан, сертификат олгосон. “Галын аюулгүй байдлын тухай хууль, эмнэлгийн барилга, тоног төхөөрөмжийн цахилгааны аюулгүй байдалд үзлэг, шалгалт зохион байгуулах ажлын удирдамж”-ийн хүрээнд ЭМГ, НЭ, ӨЭМТ, СЭМТ-ийн	100

						10 байгууллагад ҮЭ хорооны төлөөлөл болон цахилгаанчины хамтаар ажиллаж илэрсэн зөрчлийг газар дээр нь засаж арилгасан. Аймгийн онцгой байдлын газарт хүсэлт гаргаж “Галын аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах” нь сэдэвт сургалтыг 2 удаа зохион байгуулж 42 ажилтан албан хаагч хамрагдсан. Мөн цахилгааны аюулгүй байдлыг хангаж ЭМГ болон Нэгдсэн эмнэлэг нь бүх цахилгааны ил утсыг далдлах ажлыг хийсэн. Эрүүл мэндийн байгууллагын 150 мэргэжилтнийг чадвахжуулах “Нэн тэргүүнд ХАБЭА” сэдэвт сургалт зохион байгуулсан. Ажлын байрны эрсдэлийн менежмент ,эрсдэлээс сэргийлэх сэдвээр илтгэл, хэлэлцүүлэг хийсэн. рүүл мэндийн газрын гадна автозогсоолыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зогсоол болгож, тэмдэг тэмдэглэгээ хийж засварласан мөн үүдний хэсгийн налуу замыг засаж сайжруулсан. Явган хүн болон тэргэнцэртэй иргэн явах зам гарцийг машин таглуулахааргүй болгож тэмдэг тэмдэглэгээ хийсэн. Автомашины урсгалыг нэг чиглэлд болгож зохион байгуулсан. Аймгийн Засаг даргаас Удирдах ажилтны зөвлөгөөн дээр үүрэг чиглэл болгосны дагуу гэр хороололд амьдардаг ажилтан, албан хаагчдын судалгааг гаргаж батлагдсан удирдамжийн дагуу цахилгаан болон галын аюулгүй байдлын эрсдлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан. Нийт 10 үйл ажиллагаанд 288 эмнэлгийн ажилтан хамрагдсан байна.	
7.1.3.	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд хувийн ашиг сонирхлын зөрчил урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах	-	Хэрэгжил ийн хувь	90	92	Авлигатай тэмцэх газрын ЭБАТ-ын цахим сургалтад суусан. ХОМ тайланг гарган Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтэст хүргүүлсэн байна Эрүүл мэндийн газрын Шилэн дансанд Хууль зүйн байнгын хорооны 05 дугаар тогтоолын дагуу 1,2,3,4 дүгээр сарын ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг шивж байршуулсан. Нэгдсэн эмнэлгийн 37 удирдах албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг	97.8

						авлигатай тэмцэх газрын цахим сайтад хуулийн хугацаанд илгээсэн. Хасхом бөглөх эрх бүхий 33 албан тушаалтанд биечлэн болон цахимаар нийт 2 удаа сургалт зохион байгуулсан. Хуулийн хэрэгжилт 90%	
7.1.4.	Монгол Улсын Үндсэн хууль, хөдөлмөрийн харилцааг таниулан сурталчилана	-	Сургалта д хамрагдс ан хүний тоо	-	1 удаа 70 хүн	Эмнэлгийн мэргэжилтний салбар хорооноос эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарт “Эмч бидний харилцаа” сэдэвт сургалтыг ЭМГ, ЭМТҮХ болон Тэгш-Анар ХХК хамтран зохион байгуулж нийт 120 эмнэлгийн ажилтан хамрагдсан.	100
Зорилт 7.2. Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх							
7.2.1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд алсын зайн оношилгоо, зөвөлгөө, мэдээлэл солилцох (телемедицин) тусламж үйлчилгээг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд хэрэгжүүлж ажиллана.	1,000.0	- телемедицины тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	-116	- Шаардлагатай тохиолдол бүрт	Pacs.mn стандартын дагуу ашиглаж хэвшсэн ба Рентген болон компьютер томограф гэсэн 2 төрлөөр зураг байршуулж байна. 94 компьютер томографийн шинжилгээнд зөвөлгөө авч ажилласан. Үр дүн: Зөвөлгөө шатлалын тусламж үйлчилгээ нэвтэрснээр үйлчлүүлэгчийг Улаанбаатар явах урсгалыг багасгах, оношийн зөрүүтэй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж байна. 2025 онд улсын хэмжээнд шинээр нэвтрүүлсэн зурагт суурилсан алсын зайн дүрс оношилгоо, зөвөлгөөний www.pacs.mn ашиглалт 100% нэвтэрсэн.	100
7.2.2	Эрүүл мэндийн цахим мэдээллийн сангаар иргэдийг эрт илрүүлэгт хамруулж, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.	200.0	- Цахимаар эргэн дуудах тогтолцоонд хамрагдсан иргэд	Хөхний эрт илрүүлэг үзлэгт 97.3% Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт 68.5% -ийн	Хөхний эрт илрүүлэг үзлэгт 94% -аас доошгүй Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт	•Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 30-60 насны нийт 7637 эмэгтэй хамрагдахаас 4280 буюу 55.6% -ийн хамрагдалтай. Хавдрын урьдал илэрсэн 94, Үрэвслийн эсрэг эмчилгээ 85 хүнд хийгдсэн байна. Эрт илрүүлгээр хорт хавдар оношлогдсон 1. •Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 20-оос дээш насны 21404 эмэгтэй хамрагдахаас 20922 буюу 97.5%-ийн хамрагдалтай. Эмнэл зүйн үзлэгээр эерэг өөрчлөлттэй гарсан 6. 13А маягтаар 2-р шатлалд	91.0

				хамрагд алтай.	70%-иас доошгүй	илгээсэн 6. Эмчилгээнд-6, эрт илрүүлгээр оношлогдсон хавдар1 •Элэгний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт 40-65 насны нийт 29914 иргэн хамрагдахаас 29213 буюу 97.7%-ийн хамрагдсан.	
7.2.3	Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээ, эмчийн үзлэг, өвчний түүх, цаг авах, шинжилгээ авах, өвчтөн илгээхтэй холбоотой цахим соёлыг төлөвшүүлнэ.	200.0	Цахим системийн хамралт	-Ehealth программын модуль 90 хувьтай цахимжсан.	95%	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд иргэдтэй харилцах үйлчилгээг сайжруулж Callpro системийг Юнителийн OneCall системээр сольсон. Ehealth программын 100 хувь цахимжсан. Нийт цаг авч үйлчлүүлсэн иргэдийн тоо 128109. Үүнээс утсаар 15903, биеэр 112206, цуцалсан 1657, иргэн утсаар холбогдсон 10737 Төрийн үйлчилгээний нэгдсэн E-Mongolia системээр дамжуулан Эрүүл мэндийн яамнаас үзүүлдэг нийт 22 төрлийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж, иргэд хаанаас ч, 24/7 авах боломжтой болсон.	100
Зорилт 7.3 Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлэх							
7.3.1	Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангана.	-	Сар бүр тогтмол мэдээ өгдөг ЭМБ	160 ЭМБ-ын мэдээллийг цаг тухайд нь хүргэж ажилласан.	90%	Хувийн хэвшлийн 189 Эрүүл мэндийн байгууллагаас цаг хугацаандаа мэдээ ирүүлсэн 162 буюу 85.7%-тай сар бүр утсаар болон цаасан хэлбэрээр эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээг авч нэгтгэж, мэдээний чанар үнэн зөв байдал хяналт тавьж, Hinfo-3 болон цахим эрүүл мэндийн шивэлт тулгалт хийж сар бүрийн 3-ны өдөр Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлж ажилласан. Мөн байгууллагын удирдлага болон аймгийн удирдлагыг сар бүрийн 5-нд харьцуулсан үзүүлэлтийг гаргаж мэдээллээр хангаж ажиллаж байна	95.2
7.3.2	Эмнэлгийн мэргэжилтний судалгааны ажлыг дэмжиж ажиллана.	1,000.0	-Эмч, эмнэлгийн мэргэжилтний	2 удаагийн эрдэм шинжилгээний хуралд	2-аас доошгүй удаа 15-20 ЭМА оролцох	Дэлхийн эмч нарын өдөр"-ийг угтан "Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулъя" Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдсан. Эрдэм шинжилгээний бага хурал нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, шинэ технологи нэвтрүүлж нутагшуулах, эмчилгээ үйлчилгээнд	100

			эрдэм шинжилгэ эний хурал	14 судалга аны илтгэл		шинжлэх ухаанчаар хандаж нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг үзүүлэх зорилготой юм. Эрдэм шинжилгээний илтгэлд 7 судалгааны ажил танилцуулагдсан. Зохион байгуулсан нийт төсөв 1,5 сая төгрөг. Олон улсын сувилагчдын өдөр"-ийг угтан "Сувилахуйн хөгжил-2025" эрдэм шинжилгээний хуралд 8 судалгааны илтгэл хэлэлцүүлэгдэж Эрүүл мэндийн салбарын сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн дунд мэдлэг, чадварын, онолын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдсан. Зохион байгуулсан нийт төсөв 1,8сая төгрөг зарцуулсан .Нийт 56 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. Үр дүн нийт 2 удаагийн эрдэм шинжилгээний хуралд 15 судалгааны ажил хэлэлцүүлэгдсэн байна. Нийт 56 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.	
Мэдээллийн технологийн чиглэлээр: 3 зорилт 9 арга хэмжээний хэрэгжилт 96.9%-тай байна.							
8. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ							
Зорилт 8.1. Эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангаж ажиллах							
8.1.1	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулж эмнэлгийн ачаалал хуваалцах, тусламж үйлчилгээний тасралтгүй, шуурхай хүртээмжтэй байдлыг ханган үр дүнг тооцож ажиллана	200.0	-гэрээ байгуулан ажилласан эмнэлэг -Ачаалал хуваалцсан хувь	Нийт үзлэгийн 19.1%	21%	Хувийн хэвшлийн эмнэлгийн нийт үзлэг 135880 байгаа нь нийг үзлэгийн 21% эзэлж байна.12 ортой эмнэлэгийн амбулаторийн үзлэг 36224 буюу 26.6%, эмнэлэгт хэвтсэн 6793, мэс засал 344 хийсэн байна. Шүдний эмнэлгийн үзлэг 67582 буюу 49.7%, эмэгтэйчүүдийн үзлэг 9613 буюу 7%-ийг ХХЭМБ хийж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	100
8.1.2	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	3,000.0	Батлагдсан	Тушаал -4 Байгууллага 30	Тушаал-2 Байгууллага 30	2025 онд Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг гарган ЭМГ-ын даргын албан тоотоор хүргүүлсэн. 2025 онд нийт 47	100

	бүхий аж ахуй нэгж байгууллагын асуудлыг шийдвэрлэн ажиллаж, цахимд үе шаттай шилжүүлнэ		тушаалын тоо -ААНБ тоо			байгууллагын тусгай зөвшөөрлийг шийдвэрлэж ЭМГ-ын даргын 15 удаагийн тушаал гарч ажилласан байна. Үүнд: Тусгай зөвшөөрөл сунгасан 20, шинээр олгосон 15, байрлалд өөрчлөлт оруулсан 3, үйл ажиллагаа түр зогсоосон 6, тусламж үйлчилгээний чиглэл нэмсэн 2, тусламж үйлчилгээний чиглэл хассан 1 байгууллага байна. Үр дүн. Тусгай зөвшөөрөл цахимд шилжиж 47 байгууллагын асуудлыг шийдвэрлэсэн	
8.1.3	Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, мэргэжлийн удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлнэ	600.0	-Өгсөн зөвлөмж - Үнэлгээний хувь	ХШҮ 3 удаа, дундаж үнэлгээ 87.6% Өгсөн зөвлөмж 15	ХШҮ 2 удаа зөвлөмж Үнэлгээний хувь 87.5%	Эрүүл мэндийн байгууллагуудад 3 удаа хяналт шинжилгээ үнэлгээ хийж, 13 төрлийн зөвлөмж өгч ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилт 83.2% байна.	95
8.1.4	Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн байгууллагын дунд хугацааны бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	200.0	-2025-2030 он хүртэлх Стратеги төлөвлөгөө шинэчлэн боловсруулсан байна.	ЭМСалбарын 2023-2025 оны стратег и төлөвлөгөөний хэрэгжилт 91%	ЭМСалбарын 2025-2030 он хүртэлх оны стратеги төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг 90%-аас доошгүй байх	Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 2023-2025 он хүртэлх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Стратеги төлөвлөгөөний 10 зорилт 45 арга хэмжээний хэрэгжилт 95.6% байна. ЭМГ-ын даргын өгсөн чиглэлийн дагуу ЭМГ-ын 2026-2030 он хүртэл хэрэгжүүлэх Эрүүл мэндийн газрын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.	90
8.1.5	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангана.	-	- Мэдээлэл	-Хүний нөөц 92%	Хэрэгжилтийн хувь 94%	Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/352 тушаалын хэрэгжилтийг ханган ЭМЯамны 2025/10/01-ны өдрийн 2/4740 албан тооны дагуу 9 ЭМБ-дад Нээлттэй	92

	-Хүний нөөцийн -Үйл ажиллагааны -Төсөв, санхүүгийн -Мэдээллийн		тавигдсан байдал - Хэрэгжил тийн хувь	-Үйл ажиллаг аа 93% -Төсөв, санхүү 99% - Мэдээл лийн ил тод 95%		мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журмыг танилцуулж, Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах ажил үүргийн хуваарийг ЭМГ-ын даргын 2023 оны А/59 тушаалаар үүрэгжүүлж, ажлыг эрчимжүүлж ажилласан. Мөн төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285:2017 стандартыг ханган ажиллаж байна. ЗГ-ын 2021 оны 109 дүгээр тогтоолын дагуу цахим хуудсанд мониторинг хийж ажилласан. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг эрүүл мэндийн газрын цахим хаяг болон байгууллагын ил тод байдлын мэдээллийн самбарт сар бүр шинэчлэн байршуулан ажиллаж байна. Шилэн данс хөтлөлт 780 мэдээллээс 774 мэдээллийг хугацаандаа, 6 мэдээллийг хугацаа хоцроосон. Байршуулах ёстой мэдээллийг бүрэн байршуулсан боловч 6 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан тул салбарын хэмжээнд гүйцэтгэл 99,2% байна. Үр дүн: Төрийн цахим үйлчилгээ зохицуулалтын газраас shilen.gov.mn сайтад ЭМГ-ын ил тод байдлын үнэлгээг 1 дүгээр улиралд 84.29%, 2 дугаар улиралд 84.4%, 3-р дугаар улиралд 91.21% тус тус дүгнэгдсэн	
8.1.6	Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана	-	Хэрэгжил ийн хувь	81%	85%	Хүн амын эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах зорилгын хүрээнд орон нутгийн удирдлага төрийн албан хаагч нарт Жендер хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх багц сургалт зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд Шарын гол, Орхон, Хонгор сумын төрийн байгууллагын удирдлага, албан хаагч, иргэдийн төлөөлөл, ЕБС-ийн 10, 11 дүгээр ангийн 240 сурагчид, 120 төрийн албан хаагчид хамрагдсан байна. Жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх үе тэнгийн эерэг нөлөөлөгч бэлтгэх сургалт зохион байгуулж Уул уурхайн политехникийн коллеж нийт 20 оюутан хамрагдсан. Гэр бүл дэх хүүхдийн тэгш	95

						хүмүүжил, хайр халамжийн ач холбогдлыг хүүхдүүд өөрсдийн өнцгөөс илэрхийлэх, Нийгэмд жендерийн эерэг ойлголт, тэгш байдлыг сурталчлах зорилго бүхий “ЭЭЖ, ААВ БИДНИЙГ ТЭГШ ХҮМҮҮЖҮҮЛДЭГ” сэдэвт гар зургийн уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан. Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулж буй “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” үндэсний хэмжээний аянд"нэгдэж ААНБ-руу мэдээллэл сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Охидын санал, үзэл бодлыг орон нутгийн шийдвэр гаргах түвшинд хүргэж, “Охидын клуб” байгуулсан. Нийт 10 аж, ахуй нэгж байгууллагын 455 ажилтан, албан хаагчдад, давхардсан тоогоор ЕБС-ын 250 хүүхэд, СӨБ-ийн 150 хүүхэд, 623 оюутан залууст мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 82,7% байна.	
8.1.7	Гадаад дотоодын төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана. -Эрүүл Дарханчууд дэд хөтөлбөр -Шинэ технологи нэвтрүүлэгч хамт олон төсөл - Шилэн эмнэлэг 3 төсөл	50,000.0	-Төсөл хөтөлбөр ийн хэрэгжилт	90%	90%	Дотоодын төсөл, хөтөлбөрөөр ХӨСҮТ-с Хүний папилома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг идэвхүүжүүлэх сургалт, дэмжлэгт хяналт хийхэд зориулж 3,9 сая төгрөг,мөн төвийн бүсийн тархвар судлалын сургалтын санхүүжилт-11,4сая төгрөгний санхүүжилт орж зарцуулсан. Яаралтай тусламжийн үнэлгээ, авах арга хэмжээнд зориулж 10.0 сая төгрөг, дээд шатны байгууллага ЭМЯ, ХӨСҮТ зэрэг байгууллагаас Улаанбурханы нэмэлт дархлаажуулалт, Папелимо вирусын дархлаажуулалт, Улирлын томуугийн дархлаажуулалт, Сүрьеэгийн илрүүлэг, хяналт зэрэг бусад эрүүл мэндийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 103.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосны дагуу үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. 2025.03 сард “Deseret” Олон улсын байгууллагаас НЭ-ийн Поликлиник-1 тасгийн Урологи	100

						андрологийн кабинетад 13 нэр төрлийн 143 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг хандиваар хүлээлгэн өгсөн. Кёнги аймгаас Хонгор СЭМТ-д түргэн тусламжийн автомашин хандивласан. -Эрүүл Дарханчууд дэд хөтөлбөрийн хэрэгжилт 94.78% -Шинэ технологи нэвтрүүлэгч хамт олон төсөл хэрэгжилт 100%	
Зорилт 8.2. Эрүүл мэндийн байгууллагуудад өргөтгөл, засвар үйлчилгээ хийх, орчин нөхцөлийг сайжруулах, тоног төхөөрөмжөө хангахад дэмжиж ажиллах							
8.2.1	Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлэн ажиллана. (Уламжлалтын тасаг, Эмгэг судлалын ёслолын өрөө, Амбулатори 2 тасгийн засвар)	200,00 0.0	Зарцуулсан төсөв	100 сая	Гүйцэтгэлээр	Аймгийн ОНХО-ын 2024-2025 оны шилжих хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлэгт үений дурангийн мэс заслын тоног төхөөрөмж 518.0 сая төгрөгөөр Ай Эм Эс Инженеринг ХХК нийлүүлсэн, Нэгдсэн эмнэлгийн гадна авто зогсоолыг өргөтгөхөд 418.5 сая төгрөгөөр Билигт Инженеринг ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, автомашин худалдан авахад 326.2 сая төгрөг батлагдаж аймгийн ХАА-ны газар тендер зарласан боловч оролцогч ирээгүй байна. 2025 онд Нэгдсэн эмнэлгийн уламжлалтын тасгийн засвар хийхэд аймгийн төсвөөс 20.0 сая төгрөг батлагдаж засвар хийгдэж дууссан. Хонгор сумын засаг даргын нөөц сангаас 10.0 сая төгрөгийн ухаалаг дэлгэц, суурин компьютер өгсөн. Орхон сумын ОНХО-ын хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн төвийн барилгын гадна фасат, дээврийг засаж шинэчлэх ажлыг 287.9 сая төгрөгөөр Онцот Баянхайрхан ХХК гүйцэтгэж дууссан. Амбулатори-2 тасаг, сүрьеэгийн хэсэг, Уламжлалт эмчилгээний тасагт ДУА-ын хөрөнгө оруулалтаар их засвар хийгдсэн. Өсвөр үеийн кабинет, дотрын тасаг, мэс заслын тасгийн хими эмчилгээний хэсэгт тохижилт үйлчилгээг хийсэн. Хоол-Шим тэжээлийн тасаг шинээр үүссэнтэй холбоотой тоног төхөөрөмжийн суурилуулалт, цахилгааны холболтын ажлыг хийж гүйцэтгэсэн.	100

8.2.2	Сумын эрүүл мэндийн төвийн байр ашиглалт, урсгал засварын зардлыг Монгол Улсын төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.	500,00 0.0	-Урсгал засвар хийгдсэн ЭМБ-ын тасаг нэгжийн тоо	Шарын гол СЭМТ 1-2 давхрын засвар	Шарын гол СЭМТ	Нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардлыг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна. 2025 онд Нэгдсэн эмнэлэг 1,127.4 сая, Хонгор СЭМТ 106.1 сая, Орхон сэмт 101.6 сая, Шарын гол СЭМТ 882.1 сая, нийт 2,217.2 сая төгрөгийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардал олгохоор батлагдсан. Үүнээс хуваарийн дагуу Нэгдсэн эмнэлэгт 698.0 сая, Хонгор СЭМТ-д 63.6 сая, Орхон СЭМТ-д 60.4 сая, Шарын гол СЭМТ-д 346.1 сая, нийт 1,168. сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.	100
Зорилт.8.3 Салбарын хяналтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан хүний эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах, суралцах орчин нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах							
8.3.1	Хяналт шалгалтын объектод шалгуур үзүүлэлтээр эрсдэлийн үнэлгээ хийж, цахим системд мэдээллийг оруулна	200.0	Хяналтад хамаарах объектын тоо	цахим системд 1060 объект	1160 объектод эрсдэлийн үнэлгээ хийж цахим системд оруулсан байна.	Монгол улсын Засгийн газрын 2023 оны 195 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар батлагдсан Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын объектын эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур 12 үзүүлэлтийн дагуу хяналтын 6 чиглэлээр нийт 1235 объектод эрсдэлийн үнэлгээ хийж, цахим системд оруулсан.	100

8.3.2	Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 52 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ	200.0	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналтын чиглэл бүрээр нэгдсэн танилцуулга 4	Хяналтын чиглэл бүрээр шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	СХГ-аас ирүүлсэн 10-00/05, 10-00/11, 03-00/02, 10-00/13 дугаар удирдамжаар төлөвлөгөөт шалгалтанд хамрагдвал зохих нийт 52 объект буюу боловсролын 9, үсчин гоо сайхны 9, эрүүл мэндийн 16, хүнсний 18, нийт 52 объектыг 100% хамруулан төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн.Шалгалтын явцад нийт 31 объектоос дотоод орчны агаарын 122, усны 19, хоолны 24, ариун материалын 51, гадаргуугийн арчдасны 444, түүхий эд, бүтээгдэхүүний 10, нийт 670 дээж авч шинжлүүлэхэд 648 дээж буюу 96.7% нь эрүүл ахуй аюулгүй үзүүлэлтийн шаардлага хангасан, 22 буюу 3.3% нь шаардлага хангаагүй гарсан зөрчлийг арилгуулах талаар албан шаардлагад тусгуулан арилгуулсан.Шалгалтаар нийт 759 зөрчил, дутагдал илрүүлэн 360 буюу 47.4%-ийг газар дээр нь болон шалгалтын явцад арилгуулан илэрсэн зөрчлийг арилгуулахаар 576 заалттай 23 хугацаатай албан шаардлага хүргүүлсэн, албан шаардлагын биелэлт 70.2%-тай байна.Нийт 12 төрлийн хяналтын хуудсаар 52 объектын эрсдэлийг үнэлэхэд нь 29 нь бага, 18 нь дунд, 5 нь их эрсдэлтэй үнэлэгдсэн. Холбогдох 20 хууль тогтоомжийн 111 заалтын хэрэгжилт дунджаар 72.5%-тай байна.Хяналт 6 чиглэлээр хийсэн хяналт шалгалтын нэгдсэн танилцуулгыг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.	100%
8.3.3	Хяналтын 11 чиглэлээр урьдчилсан болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ	1,200.0	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга гаргасан байна.	2025 онд шинэ жил, цагаан сар, хүүхдийн баяр, наадмыг угтсан, ундны усны чанар аюулгүй байдал, ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд, бохир ус цэвэрлэгээний түвшин, хот суурин газрын хөрсний бохирдлын түвшинд, эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд, хүүхэд өсвөр үеийн кабинтийн үзүүлж буй тусламж үйлчилгээнд, бүх шатны сургалтын байгууллагын 2025-2026 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд, хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд	100%

						хяналтын 5 чиглэлээр нийт 11 чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.Шалгалтаар нийт 142 аж ахуйн нэгж байгууллага, 124 иргэний 278 объектыг хамруулан нийт 989 зөрчил дутагдал илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 237 заалттай 30 албан шаардлага хүргүүлж, 64.1%-ийн биелэлттэй, илэрсэн зөрчлийн 65.7%-ийг арилгуулсан.Хяналт шалгалтын явцад ус хангамжийн байгууллага, бохир ус цэвэрлэх байгууламж, хүн амын сууршлын бүс, хүүхдийн зуслан, ЕБС, эмэгтэйчүүдийн эмнэлэг зэрэг нийт 65 объектоос ундны усны 96, бохир усны 7, хөрсний 7, хоолны 2, арчдасны 80, агаарын 40, ариун материалын 21, нийт 253 дээж авч шинжлүүлэхэд 99.2% нь эрүүл ахуй аюулгүй үзүүлэлтийн шаардлага хангасан.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнд хадгалах хугацаа дууссан, хадгалалтын горим алдагдсан түүхий эдээр үйлдвэрлэсэн нийт 6 нэр төрлийн 3.4 кг, 250мл, 15 ширхэг, 228.0 мян.төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүнийг дотоод хяналтаар устгуулах арга хэмжээ авч, хаяг шошгын зөрчилтэй 3 нэр төрлийн 142 ширхэг 328.2 мян.төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт борлуулагчид буцаалт хийлгүүлэн баримтаар баталгаажуулсан. Нийт 24 хууль тогтоомжийн 107 заалтын хэрэгжилт дунджаар 81.2%-тай байна.Нийт 11 урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын танилцуулга тус бүрийг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахимаар хүргүүлсэн.	
8.3.4	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 ² .1-д зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх	Улсын төсөв	Хяналт шалгалтын танилцуулга	-	Хяналт шалгалтын дүнгийн танилцуулга	Удирдах дээд байгууллагын шийдвэрээр 7, иргэний өргөдлөөр 8, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр 152, нийт 162 аж ахуйн нэгж байгууллага, 7 албан тушаалтан, 9 иргэнийг хамруулан төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, нийт 1445 зөрчил дутагдал илрүүлэн 1021 зөрчил буюу 70.6%-ийг шалгалтын	100%

	бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус шалгалт хийх				гаргасан байна.	явцад арилгуулан 6 аж ахуйн нэгжид нийт 59 заалт бүхий хугацаатай албан шаардлага, 1 иргэний объектын үйл ажиллагааг зогсоох акт хүргүүлж, 6 албан шаардлагын биелэлт 80.5%-тай байна.Холбогдох хууль тогтоомж стандартын шаардлага хангахгүй 34 аж ахуйн нэгжид албан бичгээр хариу хүргүүлж, холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангасан 116 аж ахуйн нэгжид улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт, 3 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу хоолны газрын дотоод орчноос арчдасны 10, агаарын 1, ундны ус, мөснөөс 18, хоолны 6 нийт 35 дээж авч шинжлүүлэхэд 2 хоолны дээжинд гэдэсний бүлгийн нян илэрсэн, 16 усны дээжийн хариу гараагүй, 17 дээж нь эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан.2 албан тушаалтантай холбоотой асуудлыг шалган Цагдаагийн байгууллагад шилжүүлэн, 2 аж ахуйн нэгж, 5 албан тушаалтанд зөрчлийн хэрэг нээж, харьяа байгууллага руу сахилгын шийтгэл ногдуулахаар санал хүргүүлж, 2 иргэнд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан 9.300.0 мян.төгрөгийн торгууль, 1 албан тушаалтны мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 сараар хасч, 1 иргэний 10.0 мян.төгрөгийн хууль бус орлого, 3.482.514 мян.төгрөгийн улсад учруулсан хохирлыг тогтоон нийт 3.300.0 мян.төгрөгийн торгууль, 10.0 мян.төгрөгийн хууль бус орлогыг хугацаанд нь барагдуулсан, 6.000.0 сая төгрөгийн торгуулийн барагдуулах хугацаа болоогүй, 3.482.514 мян.төгрөгийн улсад учруулсан хохирол барагдаагүй байна.Иргэний 8 өргөдөл, 152 аж ахуйн нэгжийн хариуг хүргүүлсэн.	
8.3.5	Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг нэвтрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна.	Улсын төсөв	Сургалтын тайлан	-	Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж	2025 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан нийт 52 объектын 29 аж ахуйн нэгж байгууллагын 49 албан тушаалтан, 38 ажилтныг хамруулан “Дотоод хяналтыг нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтыг хяналтын 5 чиглэлээр Эрүүл мэндийн газар, ХХААГ, Боловсролын газартай хамтран зохион байгуулсан.	100%

					байгууллагыг 50 хувь хамруулсан сургалт зохион байгуулсан байна.	Аж ахуйн нэгж байгууллага бүр дотоод хяналтыг хэрхэн сайжруулах, эрүүл ахуйн зохистой дадлыг мөрдөж ажиллах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хоол хүнсний гаралтай хордлого халдвараас сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.
Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал: 3 зорилт 14 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 98%-тай байна.						

Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 чиглэл , 23 зорилт, 105 арга хэмжээг төлөвлөсөн. Хэрэгжилт 96.94%-тай байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ч.МӨНХЦЭЦЭГ

ТАЙЛАН ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЗОЛБАЯСАХ

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА



Б.ЭРДЭНЭТУЛГА

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ**

2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Хэрэгжилт		Бүгд	Чиглэл							
			Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	Хүний нөөцийг чадавхижуулах, нийгмийн баталгааг хангах	Эрүүл мэндийн санхүүжилт	Эрүүл мэндийн технологи	Эмзүйн тусламж үйлчилгээ	Мэдээллийн технологи	Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал
Зорилтын тоо		23	5	7	2	1	1	1	3	3
Арга хэмжээний тоо		105	23	37	11	4	1	6	9	14
Үүнээс	85 буюу түүнээс дээш хувьтай “Бүрэн хангалттай”	99	21	35	11	3	1	6	8	14
	70-85 хүртэл хувь “Хангалттай”	5	2	1		1			1	
	70 хүртэл хувь “Хангалтгүй”	1		1						
Хэрэгжилтийн хувь		96.94%	96.5	96.4	99	88.75	100	100	96.9	98
Хэрэгжилтийн оноо		4.85	4.83	4.82	4.95	4.44	5.0	5.0	4.85	4.9

Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 чиглэл , 23 зорилт, 105 арга хэмжээний хэрэгжилт 96.94%-тай байна.

Үнэлгээ хийсэн :

Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн

Ч.Мөнхцэцэг

Үнэлгээ хянасан:

Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга

Б.Золбаясах

Үнэлгээг баталсан:

Эрүүл мэндийн газрын дарга

Б.Эрдэнэтулга

